

“Монголын төмөр зам” ТӨХК нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 726 дугаар тогтоолоор баталсан компанийн шинэчилсэн дүрмийн хүрээнд 7 газар, 17 хэлтэс, алба, 3 төслийн нэгж, 13 анги хэсгийн бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

1. ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗАР

Тайлант хугацаанд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах, ажилтнуудын сахилга батыг сайжруулах ажлын хүрээнд компанийн удирдлагын шуурхай хуралдааныг тухай бүр зохион байгуулж, Засгийн газар болон холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийг хангах талаар газар, албадын дарга нарт үүрэг, чиглэл өгч, хэрэгжилтийг хангаж ажиллав. Энэхүү ажлын хүрээнд:

Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 434 дүгээр тогтоолоор “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн үйл ажиллагааг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгож “Монголын төмөр зам” ТӨХК-д нэгтгэхээр шийдвэрлэсний дагуу “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн хөрөнгийг балансаас баланст шилжүүлэн авсан бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор компанийн зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн орно тооны дээд хязгаарыг 669 орон тоотойгоор баталж үйл ажиллагаагаа явуулж байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын “Бүрэн цахимжсан, бүтээмжийг нэмэгдүүлж, хариуцлага үр дүнг тооцох жил” болгон зарлах тухай 01 тоот албан даалгавар, “Монголд зочлох жил”-ийн хүрээнд Зам, тээврийн салбарт авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 02 тоот албан даалгавар, 04 тоот албан даалгаврын биелэлтийг тус тус ханган ажиллаж байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалын хэрэгжилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тус тус ханган ажиллаж байна.

“МТЗ” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 10 дугаар тогтоолын хавсралтаар “Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар 2023 онд хэлэлцэх асуудал, ажлын төлөвлөгөө”-г батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн үйл ажиллагаатай холбоотой 13 тогтоол батлагдсан бөгөөд тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн ханган ажиллаж байна.

Компанийн Гүйцэтгэх захирал нь компанийн дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж байна. Компанийн үйл ажиллагааг хэвийн тогтвортой явуулах, ажлын хариуцлага, сахилга батыг сайжруулах ажлын хүрээнд тайлант хугацаанд Гүйцэтгэх захирлын 316 тушаалыг албажуулан гаргасан бөгөөд үндсэн үйл ажиллагаатай холбоотой “А” тушаал 82, хүний нөөцтэй холбоотойгоор “Б” тушаал 234 гарсан байна.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шүүр” ажиллагааны хүрээнд 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 2023 оны 04 дүгээр сарын 19-ны өдрүүдэд Монгол Улсын Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газраас ажлын хэсгийн гишүүд “МТЗ” ТӨХК-д ирж ажилласан бөгөөд Захиргааны үйл ажиллагаатай холбоотой бичиг баримтуудыг хугацаанд нь гарган өгч ажилласан.

Нийслэл Улаанбаатар хотын авто замын Түгжрэлийг бууруулах үндэсний хорооны зөвлөмжийг хэрэгжүүлж, хийж гүйцэтгэсэн ажлын тайланг 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр Зам, тээврийн хөгжлийн яаманд цахимаар хүргүүлсэн.

“Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “МТЗ” ТӨХК-ийн хариуцан хэрэгжүүлж байгаа төмөр замын томоохон төслүүдэд 2024 оноос эхлэн Улаанбаатар хотоос хөдөө орон нутагт шилжүүлэхээр төлөвлөж буй албан хаагчдын судалгааг маягтын дагуу боловсруулж, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн захиргаа, удирдлагын газарт 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр хүргүүлсэн.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал, компаниас зохион байгуулж буй хэвлэлийн хурал, бусад хурал уулзалтуудын өмнөх бэлтгэл ажил, техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг тухай бүр хангаж, хурлын заалны бэлэн байдлыг хариуцан ажиллаж байна.

Албан хаагчдын ажлын байрны цэвэрлэгээ, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдалд өдөр тутам хяналт тавьж, эд хөрөнгөтэй холбоотой эвдрэл гэмтлийг тухай бүр засварлах ажлыг зохион байгуулж ажиллав.

Компанийн албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа дунд оврийн автобус, микро автобус, автомашинуудын техникийн бэлэн байдал, аюулгүй байдлыг тухай бүр хангуулж, Цогтцэций өртөө, зөрлөгүүдэд ажиллаж байгаа ээлжийн ажилтнуудыг ээлжийн хуваарийн дагуу хүргэх ажлыг зохион байгуулж байна. Тайлант хугацаанд автомашинуудад тогтмол үзлэг оношилгоог хийж, акт тогтоосны дагуу засвар үйлчилгээнд оруулан ажиллаж байна.

1.1. Шуурхай хуралдаан:

Тайлант хугацаанд удирдлагын шуурхай хуралдаан 14 удаа хуралдаж давхардсан тоогоор 157 үүрэг даалгавар өгөгдсөн бөгөөд үүрэг даалгаврын хэрэгжилтийг бүрэн ханган ажиллаж байна.

Тайлант хугацаанд Зам, тээврийн хөгжлийн сайдын шуурхай хуралдаан 12 удаа хуралдаж үүрэг даалгавар өгсөн бөгөөд шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг Зам, тээврийн хөгжлийн яаманд хугацаанд нь хүргүүлж хэрэгжилтийг хангаж ажилласан.

1.2. Архив, албан хэрэг хөтлөлт

Архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах, тоо бүртгэл, баримт бичгийн хайлт, ашиглалтын үйл ажиллагааг хөнгөн шуурхай болгох, эх баримтыг ашиглалтаас чөлөөлөх зорилгоор байнга хадгалах удирдлагын баримтыг 100% цахим хэлбэрт шилжүүлж, цахим мэдээллийн сан үүсгэн ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 434 дүгээр тогтоолоор “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн үйл ажиллагааг зогсоож, “Монголын төмөр зам” ТӨХК-тай нэгтгэсэнтэй холбогдуулан “Архивын баримт бичиг хүлээлцэх комисс” нь нийт 460 хадгаламжийн нэгж цаасан суурьтай баримтыг хүлээлцсэн.

Компанид ирсэн бичгийг цаасан хэлбэрээр, цахим шуудангаар тус тус хүлээн авч байгаа бөгөөд тайлант хугацаанд харилцагч байгууллагуудаас нийт 977 албан бичиг ирснийг бичиг хэргийн мэдээллийн санд бүртгэн, Гүйцэтгэх удирдлагад танилцуулан цохолтын дагуу холбогдох нэгж, ажилтанд компанийн дотоод сүлжээгээр шилжүүлсэн.

- Шийдвэрлэж хариу илгээсэн 375 албан бичиг;
- Танилцуулж хаасан 456 албан бичиг;
- Хариу өгөхөөр хүлээгдэж байгаа 146 албан бичиг байна.

Тайлант хугацаанд 899 албан бичгийн төслийг газар, нэгжүүдээс хүлээн авч хэвлэмэл хуудсанд стандартын дагуу буулган албажуулж, холбогдох газарт хүргүүлэн ажилласан. Дотоод албан бичиг 120 албажсаныг холбогдох газар, нэгжид хүргүүлсэн.

1.3. Хүний нөөцийн чиглэлээр:

Компанийн 2023 оны бүтэц, орон тоог Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор 669 орон тоотойгоор баталсантай холбогдуулан газар, алба, нэгжүүдийн чиг үүрэг, нийт ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлуулж өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Төв оффис, Цогтцэций өртөө, Төмөртэй өртөөний ажилтнуудын шилжилт хөдөлгөөний мэдээллийг тухай бүр “Докс” и-оффис системд бүртгэж, ажилтнуудын хувийн хэргийн нөхөн бүрдүүлэлтийн баяжуулалтыг тогтмол хийн ажиллаж байна.

Сул ажлын байранд ажил горилогчийн сонгон шалгаруулалтыг холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд нээлттэйгээр зохион байгуулж, нээлттэй ажлын байрны зарыг компанийн www.mtz.mn сайт, нийгмийн сүлжээний хэрэгслүүд болон өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдийг ашиглан байршуулан ажиллаж байна.

Компанийн ажилтнуудын нийгмийн баталгааг хангах, ажиллах орчин нөхцлийг сайжруулах хүрээнд цалингийн судалгааг хийж, судалгааг үндэслэн компанийн цалингийн шатлалыг шинэчлэн баталсан.

Компанийн хөдөлмөрийн харилцааг удирдан зохион байгуулах ажлын хүрээнд тайлант хугацаанд үндсэн болон туршилтын гэрээгээр 203 ажилтан шинээр томилогдож, 50 ажилтантай хөлсөөр ажиллах гэрээг байгуулсан.

2023 оны эхний хагас жилийн байдлаар хүний нөөцтэй холбоотой 234 Б тушаал гарсан. Агуулгаар нь ангилан авч үзвэл:

- Ажилд томилох тухай - 60
- Туршилтын хугацаанд ажилд томилох тухай - 8
- Сахилгын шийтгэл ногдуулах тухай - 13
- Ажлаас чөлөөлөх тухай - 31
- Жирэмсний амралт олгох тухай - 2
- Тэтгэмж олгох тухай - 15
- Чөлөө олгох тухай - 14
- Бусад - 91

Мөн ажилтнаас ирүүлсэн 92 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлүүлэн, холбогдох дүрэм, журмын дагуу зохих арга хэмжээг авч ажилласан.

Нийт ажилтнуудын ажлын цаг ашиглалтыг сайжруулах чиглэлээр ажилтнуудын цагийн бүртгэлд сар бүр тогтмол хяналт тавьж ажиллаж байна.

Компанийн ажилтнуудыг сургалтад хамруулсан байдал:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны “Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай” 46 дугаар зарлигийн хэрэгжилтийг ханган ажиллах хүрээнд “Монгол бичгийн сургалтын хөтөлбөр”-ийг батлуулсан бөгөөд “Хан төгс ур” НҮТББ-тай хамтран “Үндэсний бичгийн зөв бичих дүрмийн үндсэн зарчмууд, дүрэм аргачлалыг таниулах нь” сэдэвт Монгол бичгийн анхан болон дунд шатны 32 цагийн багц сургалтыг зохион байгуулж, сургалтад компанийн 70 ажилтныг хамруулсан.

Мөн “Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь”, “Байгууллага хамт олны харилцааны соёлыг хөгжүүлэх нь” сэдэвт сургалтуудыг тус тус зохион байгуулсан.

1.4. Худалдан авах ажиллагаа:

Компанийн 2023 оны бараа, ажил үйлчилгээ худалдан авалтын батлагдсан төлөвлөгөөний дагуу тайлант хугацаанд 22 удаагийн тендер шалгаруулалт ТБОНӨХБАҮХАТ хуулийн хүрээнд зарлагдсан.

- Эхний хагас жилийн байдлаар 8,927,215,768 төгрөгөөр батлагдсан төсөвт өртөг бүхий 21 худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн хүрээнд зохион байгуулан 7,507,776,936 төгрөгөөр гэрээ байгуулан бараа, ажил, үйлчилгээг хүлээн авах ажил үргэлжилж байна.
- Батлагдсан төсөвт өртгөөс 1,419,438,832 төгрөгийн хэмнэлттэй худалдан авах ажиллагааг зохион байгуулсан.

Худалдан авах үйл ажиллагааны холбогдох мэдээ, мэдээллийг тухай бүр нь www.shilendans.mn болон компанийн цахим хуудас [/www.mtz.mn/](http://www.mtz.mn/), Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn сайтуудад тус бүр байршуулан мэдээллийн ил тод байдлыг ханган олон нийтэд мэдээлэн ажиллаж байна.

1.5. Хууль, эрх зүйн чиглэлээр:

Компанийн хэмжээнд дагаж мөрдөх дүрэм, журам, заавар зэрэг эрх зүйн баримт бичгүүдийг боловсруулах, удирдлага болон бүтцийн нэгжүүдийг хууль эрх зүйн мэргэжлийн зөвлөгөөгөөр хангах, компанийн дотоодод хэрэглэгдэх дүрэм, журмуудыг олон улсын болон дотоодын хуулийн шаардлагад нийцүүлэн боловсруулахад хяналт тавих, компаниас боловсруулан гарч буй гэрээний төслийг хянах, бусад хууль эрх зүйн акт, дүрэм, журам, хөтөлбөр, төсөл, төлөвлөгөө, заавар, Гүйцэтгэх захирлын тушаалын хууль эрх зүйн үндэслэлийг хянах, зөвлөгөө өгөх чиглэлээр ажиллаж байна.

Засгийн газрын 2022 оны 116 дугаар тогтоолын дагуу “Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн” чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх тусгай зориулалтын компанийн Хувьцаа эзэмшигч “Монголын Төмөр Зам” ТӨХК болон “Эссенз саплайз” ХХК-ийн хооронд байгуулах Хувьцаа эзэмшигчдийн гэрээний төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллан зарчмын зөрүүтэй саналыг нэгтгэн төслийн нэгж болон хөрөнгө оруулагч талд хүргүүлсэн.

Засгийн газрын 2022 оны 116 дугаар тогтоолын дагуу “Чойбалсан-Хөөт-Бичигт” чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх тусгай зориулалтын компанийн Хувьцаа эзэмшигч “Монголын Төмөр Зам” ТӨХК болон “Ийст корридор рэйлрөүд” ХХК-ийн хооронд байгуулах Хувьцаа эзэмшигчдийн гэрээний төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллан зарчмын зөрүүтэй саналыг нэгтгэн төслийн нэгжид хүргүүлсэн.

“Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн” чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх тусгай зориулалтын компанийн дүрмийн төслийг боловсруулсан.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай албан бичгийн төслийг боловсруулж албажуулан 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 01/683 тоот албан бичгээр “Монголиан порт групп” ХХК-д хүргүүлсэн.

Гэрээ, эрх зүйн нийтлэг асуудлаар:

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаатай холбоотой нийт 90 гэрээг хянаж, баталгаажуулах ажлыг бусад газар, нэгжтэй хамтран зохион байгуулсан. Үүнд:

- Үйлчилгээ үзүүлэх гэрээ -16
- Ачаа тээврийн гэрээ – 7
- Худалдах, худалдан авах гэрээ -21
- Төслийн санхүүжилтийн гэрээ- 1
- Түрээсийн гэрээ – 18
- Ажил гүйцэтгэх гэрээ – 22
- Суурь бүтэц ашиглуулах гэрээ – 2
- Хамтран ажиллах гэрээ – 3
- Хөлсөөр ажиллах гэрээ – 9

2. ДОТООД АУДИТ

Дотоод аудитын алба 2023 оны эхний хагас жилийн байдлаар 10 чиглэлээр үйл ажиллагаа явуулж, тайлан мэдээлэл хүргэж, дотоод хяналт, аудитын 114 санал, дүгнэлт бүхий 30 зөвлөмж, дүгнэлт холбогдох газар, албадад зөвлөмж хүргүүлсэн. Тухайлбал:

• Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр:

Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуульд заасны дагуу шилэн дансны мэдээг цахим мэдээлэлд оруулсан эсэхэд хяналт тавьж, хуулийн хугацаанд бүрэн мэдээллийг оруулсан. Шилэн дансны 2023 оны 1-р улирлын тайлан, мэдээллийг 2023 оны 04 дугаар сарын 25-ны өдөр 03/655 тоот албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яаманд, цахимаар Сангийн яаманд тус тус хүргүүлсэн. Шилэн дансны 5-р сарын тайлан, мэдээг 2023 оны 6 дугаар сарын 07-ны өдөр цахим мэдээлэлд бүрэн оруулсан.

- **Худалдан авах ажиллагааны чиглэлээр:**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг 2022 онд “Монголын төмөр зам” ТӨХК нь бүрэн ханган ажилласан. 2022 оны 4 дүгээр улирлын байдлаар тус компанийн худалдан авах үйл ажиллагаанд дотоод аудит хийж, тайланг 2023 оны эхний улиралд багтаан шилэн дансны цахим сайтад байршуулсан. 2023 оны 1-р улирлын худалдан авах ажиллагаанд дотоод аудит хийж холбогдох газруудад дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлсэн.

- **Үндэсний аудитын газрын аудитын тайлан, дүгнэлтийг хэрэгжүүлэх чиглэлээр:**

“МТЗ” ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийгдсэн Үндэсний аудитын газрын тайлан, дүгнэлтийг 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдөр ирүүлсэн. Үндэсний аудитын газрын шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах, зөвлөмж хэрэгжүүлэх батлуулсан бөгөөд зөвлөмжийн хэрэгжилтийг хангах хүрээнд газар, нэгжүүд илэрсэн зөрчлийг арилгах, явц байдлыг мэдээлэх, тайлагнах хугацааг тогтоон баталгаажуулж ирүүлэх ажиллагаа хийгдэж байна.

- **Бүс нутгийн Логистикийн төвийн үйл ажиллагаа, санхүүд аудит хийх чиглэлээр:**

Замын- Үүд дэх Бүс нутгийн Логистикийн төвийн 2022 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийж, 7 санал бүхий зөвлөмжийг 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдөр холбогдох нэгжид хүргүүлсэн. Бүс нутгийн Логистикийн төвийн санхүүд аудит хийх удирдамжийг батлуулсан бөгөөд 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдөр аудитын хийж дуусгахаар ажиллаж байна.

- **Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон бизнес төлөвлөгөөний төлөвлөгөөний хэрэгжилтийн чиглэлээр:**

Компанийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, компанийн бизнес төлөвлөгөөний биелэлтэд дотоод аудит хийж, дүгнэлт, санал, зөвлөмжийг газар, албадад хүргүүлсэн.

- **Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагаа, өмч, эд хөрөнгийн тооллогын чиглэлээр:**

Компанийн эд хөрөнгийн 2023 оны I дүгээр улирлын тооллого явуулах комиссын бүрэлдэхүүнд ажиллаж 2023 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар компанийн аж ахуйн агуулахын үлдэгдлийг тоолж, протокол хөтлөн үлдэгдлийг баталгаажуулсан.

- **Эрсдэлийн үйл ажиллагаа, эрсдэлийн шинжилгээний чиглэлээр:**

Компанийн Эрсдэлийн удирдлагын хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, эрсдэлийн үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөг баталсан. Шивээхүрэн-Сэхээ хилийн боомтын нарийн царигийн төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл, Баруун болон зүүн босоо чиглэлийн төмөр замын төсөл, “Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн төмөр зам” ХХК болон “Чойбалсан-Хөөт-Бичигт төмөр зам” ХХК байгуулах асуудалд тус тус эрсдэлийн шинжилгээ хийж Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж танилцуулсан.

- **Зам, тээврийн хөгжлийн яамнаас өгсөн чиглэл, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх чиглэлээр:**

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаартай тушаалаар баталсан харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журмыг үндэслэн компанийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний сар, улирлын тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тухай бүр Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлж ажилласан. 2023 оны II улиралд төлөвлөгөөний биелэлтийг 50 хувьд хүргэх шийдэл, санал, дүгнэлтийг 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 03/623 тоот албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн

яаманд хүргүүлсэн. Зам, тээврийн салбарыг 2023 онд “Бүрэн цахимжсан, бүтээмж хариуцлагыг нэмэгдүүлж, үр дүнг тооцох жил” болгон зарласантай холбогдуулан ажилтан, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг сар бүр дүгнэж ажиллахаар компанийн 7 газар, 1 хэлтэс, 21 албадын нийт ажилтнуудын хийж гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэл, тайлан ирүүлсэн байдалд дотоод хяналт хийж, санал, зөвлөмж гаргаж холбогдох нэгжид хүргүүлсэн.

• **“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын ажлыг дүгнэх чиглэлээр:**

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны тогтоол, шийдвэр, өгсөн албан даалгаврын биелэлт, Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан Гүйцэтгэх захирлын онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлт, үйл ажиллагааны 2022 оны тайланд дотоод хяналтын ажлыг хийж гүйцэтгэв.

• **Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр:**

Улсын Их хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилт, биелэлтийг 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 03/742 тоот албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Авлигыг үл тэвчих, олон нийтийг соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж, Зам, тээврийн хөгжлийн яаманд 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 03/265 тоот албан бичгээр хүргүүлсэн. Авлигын нийгмийн хор аюулыг тайлбарлан таниулах, сурталчлах, авлигаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах талаар Авлигатай тэмцэх газарт 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 03/402 тоот албан бичиг хүргүүлсний дагуу Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс 2023 оны 06 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд зохион байгуулсан “Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийг бэлтгэх сургалт”-д тус компанийн төлөөллийг хамруулсан.

2022 оны байдлаар ХАСХОМ шинээр гаргасан-15, хасагдсан мэдүүлэгч гаргагч-12, Ашиг сонирхлын мэдэгдэл гаргасан -153 /давхардсан тоогоор/ албан тушаалтан бол ХАСУМ болон ХАСХОМ бүрдүүлэлтийн чиглэлээр 2023 оны 02 дугаар сарын 15-ны байдлаар нийт 22 эрх бүхий албан тушаалтан ХАСХОМ мэдүүлсэн. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор шинээр баталсан “МТЗ” ТӨХК-ийн зохион байгуулалтын бүтэц, бусад төрийн оролцоотой компанийн албан тушаалд нэр дэвшсэн 21 хүний Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, дүгнэлт гаргуулж ажилласан.

• **Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, эрх зүйн актын хэрэгжүүлэх чиглэлээр:**

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2022 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” 94 дүгээр тушаалын дагуу ТӨБЗГ-ын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 01/ТТЗ-ЗБТ дугаартай шалгалтын удирдамжаар баталсан “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн хэрэгжилт, “Зүүнбаян төмөр зам ХХК-ийн үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд дотоод хяналтын албаны ажилтнууд орж ажилласан. Монгол Улсын Засгийн Газраас 2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарласантай холбоотойгоор хэрэгжүүлж байгаа “Шүүр” ажиллагааны хүрээнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн ХЭГ/595 дугаартай албан бичиг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А-1/482 дугаартай албан бичгээр өгсөн чиглэлийн хүрээнд холбогдох арга хэмжээг зохион байгуулсан. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн удирдамжийн дагуу томилсон Салбарын хяналтын газрын хяналт шалгалтын төлөөлөлд дотоод хяналтын нэгжийн 2023 оны эхний хагас жилд хийсэн үйл ажиллагааг танилцуулсан.

3. САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ГАЗАР

3.1. Нягтлан бодох бүртгэлийн алба:

“МТЗ” ТӨХК-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан балансыг хууль, дүрэм, стандартын дагуу үнэн зөв бэлтгэн 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөр тайлагнав.

Компанийн 2023 оны I дүгээр улирлын Санхүүгийн тайлан балансыг хууль, дүрэм, стандартын дагуу үнэн зөв бэлтгэн 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдөр тайлагнасан.

- 2023 оны I дүгээр улирлын орлогыг анхан шатны баримтад үндэслэн санхүүгийн программд бүртгэв.
- 2023 оны I дүгээр улирлын зардлын гүйлгээг хянан, баталгаажуулан санхүүгийн программд бүртгэв.
- Төсөв, захиалгын дагуу бараа материалын орлого, зарлагын гүйлгээг анхан шатны баримтад үндэслэн бүртгэн 2023 оны I дүгээр улирлын бараа материалын тайланг бэлтгэв. /хангамж, сэлбэг, бичиг хэрэг, шатахуун гэх мэт/
- 2023 оны I дүгээр улиралд бараа материалтай холбоотой үүссэн авлага, урьдчилж төлсөн тооцоо, өр төлбөрийг харилцагч бүрээр үлдэгдлийг тулган баталгаажуулав.
- Шатахуун тос, тосолгооны материалын зарлагын гүйлгээг тооцооны хуудас, бусад анхан шатны баримтад үндэслэн бүртгэв.
- Нягтлан бодогч нар хариуцсан дансдын өглөг, авлагын тооцоог баримтаар хааж бүртгэв.
- 2023 оны I дүгээр улирлын НДШ-ийн тайланг Нийгмийн даатгалын газарт ХХОАТ-ын тайланг Татварын ерөнхий газарт тус тус илгээсэн.

Компанийн Санхүүгийн эхний хагас жилийн санхүүгийн тайлан баланс гаргах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

2022 оны Санхүүгийн тайланд хийсэн Үндэсний аудитын газрын шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. Гүйцэтгэх захирлын 2023.03.09-ний өдрийн А/37 тоот тушаалаар компанийн төв байр, Төмөртэй өртөө, Замын-Үүдийн Логистикийн төв, Шилжүүлэн ачих цогцолборт эд хөрөнгийн тооллого хийж, хөрөнгийг хариуцагчаар картлах ажлыг зохион байгуулсан.

Компанийн санхүүгийн Diamond 5.0 програмыг шинэчлэн сайжруулж “Смарт Ложик” ХХК-ийн “Smart Accounting” программыг сонгон нэвтрүүлэлт, туршилтын үе шатандаа хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 434 дүгээр тогтоолын хүрээнд “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн архив бичиг хэрэг, гэрээ эрхзүй, хүний нөөцтэй холбоотой материал болон эд хөрөнгийг хүлээлцэж, акт үйлдсэн. Компани хоорондын хамтарсан тооллогын ажлын хэсгийн тайлан, акт болон хөрөнгийн жагсаалтыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж, хөрөнгө балансаас балансад шилжүүлэн бүртгэх тухай 112 дугаар тогтоол гаргуулж, хөрөнгийг бүртгэлд тусгаж байна.

“Тавантолгой төмөр зам” ХХК, “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн засаглал, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх Дэд ажлын хэсэгт орж ажилласан.

3.2. Эдийн засгийн алба:

Компанийн хэмжээнд хангамжийн материал, бичиг хэрэг, дотоод, гадаад томилолттой холбоотой төсвүүдийг зорилтот түвшний төлөвлөгөөний дагуу боловсруулж батлуулан ажиллаж байна.

Үндэсний аудитын газраас ирүүлсэн алдаа зөрчлийн 35-р зүйл буюу “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой” асуудлын тайлбарыг эдийн засгийн албанаас байршуулах тайлан мэдээний хүрээнд бэлтгэн хүргүүлсэн.

Дохиолол холбооны чиглэлээр шаардлагатай тоног төхөөрөмжүүд болон Тетра системийн суурин болон гар станцын түрээсийн үйлчилгээний жишиг тарифыг тус тус боловсруулсан.

4. ИНЖЕНЕР ТЕХНОЛОГИЙН ГАЗАР

Зүтгүүрийн аж ахуйн алба:

Зүтгүүр ашиглалтын тайлан, түлшний зарцуулалтын тайлан, зүтгүүрийн чанарын үзүүлэлтүүдийг тухай бүр тайлагнан ажиллаж байна.

Зүтгүүр үйлдвэрлэгч “Wabtec” компаниас зүтгүүрийг худалдан авах талаар ажлын хэсэг байгуулан судалгааны ажил хийгдэж байна.

Илчит тэрэгнүүдийн техникийн байдал муу байгаатай холбоотойгоор илчит тэрэгнүүдийн техникийн байдал хэвийн болтол Зүүнбаян-Цогтцэций хэсэглэлд мөрдөх өртөө, зөрлөгүүд хооронд аялах хугацаа, тоормосын найдвартай ажиллагаа шалгах цэг, жингийн нормын түр цахилгаан гаргаж мөрдүүлж ажилласан.

Галт тэрэгний хурд хязгаарласан гүүрүүдийг нэмэлт хаших төмөрөөр тоноглож тогтоосон хурдыг сэргээхтэй холбоотой шаардлагыг тогтмол тавьж ажилласан.

Илчит тэрэгний цэвэрлэгээний хуваарийг шинэчилж, цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийн ажиллаж байна.

Цогтцэций өртөөний зам дагуух элснээс дээж авч “Геологийн төв лаборатори”-д шинжлүүлсэн бөгөөд шаардлага хангасан тул аж ахуйн нэгж байгууллагаас элс худалдан авах ажлыг зогсоож, өөрсдийн хүчээр элсийг бэлтгэн нөөц.

Электроник инженер, засварын хүлээн авагч, засварын ажилтнуудын хамтарсан баг DF7g-2401 илчит тэргэнд гарч байгаа гэмтлийн шалтгааныг тодорхойлж ЭПК-г түр горимд шилжүүлэн ажилласан бөгөөд DF7g-2401 сэлгээний зүтгүүрийг Төмөртэй өртөөнөөс татан авч, 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн “ТТЗ” ХХК-д түрээсээр ажиллуулж байна.

СКД4В серийн 2303, 2304, 2305 илчит тэрэгнүүд нь хөдөлгүүрийн шахалтын зэрэг багассан, чадал хязгаарлагдсан санамжтай явж байна. Тус илчит тэрэгнүүдэд 1 сарын “В” урсгал үйлчилгээг хийж гүйцэтгэсэн.

СКД4В-2301 илчит тэргэнд шаардлагатай сэлбэг хэрэгслийг захиалсан бөгөөд түр хүйтэн горимд зогсож байна.

“УБТЗ” ХНН-ийн Улаанбаатар татах хэсгийн Хими-техникийн лаборатороор СКД4В серийн 2301, 2303, 2304, 2305, DF7g-2401 илчит тэрэгнүүдийн хөдөлгүүрийн тосны дээжид сорилт шинжилгээ хийлгэсэн бөгөөд №35/2023 тоот албан бичгээр хариуг хүлээн авч дүгнэлт гарган ажиллаж байна.

Гүйцэтгэх удирдлагын зөвшөөрлийн дагуу ES44ACi-2101 зүтгүүрийн зогсоолын түрээсийн гэрээг хийж, дугаар авч “УБТЗ” ХНН-д шилжүүлсэн.

Төмөртэй өртөөний сэлгээний халаалгийн маршрутыг Цогтцэций өртөөнд ашиглахаар татан авсан.

Засвар үйлчилгээ:

СКД4В-2302 илчит тэргийг засварлах тендерийг зарлаж шалгарсан байгууллагад илчит тэргийг хүлээлгэн өгч БНХАУ-д засварыг хийлгэж байна.

EVO-MR2101 илчит тэргэнд Бүгд найрамдах Казахстан улсын “Transportian Global” компанийн техникийн зөвлөгчийн хамт үзлэг хийсэн.

Вагоны аж ахуйн алба:

Цогтцэций өртөөнд баригдсан Зэхэлтийн депо, ачааны вагоны урсгал засварын цех, Замын машин механизмын цехийн барилга угсралтын ажлын явц, гүйцэтгэлд хяналт шалгалт хийж, дутуу хийгдсэн ажлуудын талаар комиссын акт үйлдэж гүйцэтгэгч байгууллагад хүлээлгэн өгсөн.

Цогтцэций Зүүнбаян чиглэлийн төмөр замын зүгшрүүлэлтийн тээвэрлэлтэд вагоны аж ахуйн чиглэлээр хэвийн үйл ажиллагааг хангах, шаардлагатай зохион байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Техник үйлчилгээний хэсгүүдийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж

ажиллаж байгаа ба техник үйлчилгээний ажилтнуудад батлагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу сургалтыг зохион байгуулан ажилласан.

Вагоны аж ахуйн албаны хэмжээнд хөтлөгдөх бичиг баримтуудын жагсаалт, загвар, хөтлөх зааврыг боловсруулсан. Мөн техник үйлчилгээний хэсэгт мөрдөгдөх “Салгалттай урсгал засварын технологийн горим”-ыг боловсруулах шатандаа явж байна.

Вагоны аж ахуйн албаны хэмжээнд “Ашиглагдаж байгаа хэмжих хэрэгсэл ашиглах заавар”-ыг боловсруулан батлуулсан бөгөөд холбогдох сургалтыг ажилтнуудад зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

“МТЗ” ТӨХК-ийн эзэмшлийн 245 вагонуудын их засварт оруулах тендер зарлагдсан бөгөөд ачааны вагоныг зуны тээвэрт бэлтгэх үзлэг засварыг өөрийн эзэмшлийн 332 вагонд хийж гүйцэтгэхэд хяналт тавьж ажилласан.

Хөдлөх бүрэлдэхүүний насжилтийн судалгааг боловсруулан Зам, тээврийн хөгжлийн яаманд 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр хүргүүлсэн.

Ачааны вагонуудын эд ангийн дугаарыг бүртгэлжүүлсэн бөгөөд ачааны вагонуудын засварын хугацаа дуусч байгаатай холбогдуулан засварын хугацааг сунгуулах талаар “УБТЗ” ХНН, Зам, тээврийн хөгжлийн яаманд холбогдох хүсэлтийг тус тус хүргүүлсэн.

DFg7 зүтгүүрийг түрээсээр “ТТЗ” ХХК-д түрээслүүлэх талаар гэрээ, холбогдох баримт бичгийг боловсруулав.

2101 зүтгүүрийг үзлэг хийлгэх, хос дугуй зорох ажлыг гүйцэтгэх, их засварт бэлтгэхээр Улаанбаатар зүтгүүрийн депод судалж байна.

Статистик мэдээлэл, технологийн алба:

Дотоод файл дамжуулах “Share” серверийн тохиргоог нийт ажилтнуудын компьютерт суулгасан бөгөөд өдөр тутмын үйл ажиллагаанд тогтмол ашиглан ажиллаж байна.

Компанийн бүтэц, орон тоо шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан шилжин орж ирсэн 30 ажилтанд албаны и-мэйл хаягыг нээж, “Докс” и-оффис программд бүртгэж, нэвтрэх нэр болон нууц үгийг үүсгэж ажилласан.

Байгууллагын интернет хурдыг сайжруулах хүрээнд Wifi төхөөрөмжийг шинэчилж, “Zoom” программ хангамжийн албан ёсны лизенцийг худалдан авч байгууллагын цахим хурал, уулзалтын бэлэн байдлыг бүрэн хангаж ажиллаж байна. Мөн Microsoft office 365 программын бүртгэлийг үүсгэн өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж байна.

Байгууллагын ажилтнуудын компьютерийн аюулгүй ажиллагааг хангах хүрээнд вирусны албан ёсны лицензтэй программ хангамжийн 100 ширхэг лицензийг захиалж, бүртгэлжүүлэн, ажилтнуудын компьютерт суулгахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

Компанийн 6 дугаар давхарын оффист цагийн бүртгэлийн системийг шинээр суурилуулж, 200 гаруй ажилтнуудын цагийн бүртгэлийн карт, царай уншуулах датаг үүсгэсэн бөгөөд төв оффисын ажилтнуудын ажлын үнэмлэхийг ажилтнуудад хүлээлгэн өгсөн.

Зураг төслийн алба:

0-416.165км, Цогтцэций өртөөний дэвсгэр зураг, дагуу огтлолын зураг, хөндлөн огтлолын зураг, газар шорооны ажлын тоо хэмжээ, нэг маягийн хөндлөн огтлолын зураг, зам төмрийн богиносолтын тооцоо, гүүр тойрох замууд, 195км, 196км, 210км-ын гүүрэн дэх замуудын түвшингийн өөрчлөлтийн ажлын зургуудыг тус бүр дугаарлан, дотоод товъёог, баталгааны хуудас, тус бүрийн нүүр үйлдэн улсын комисст хүлээлгэн өгөх зураг төслийн бүрдэл 100%-ийн гүйцэтгэлтэй байна.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416.1км төмөр замын хоорондын замын гүйцэтгэлийн зураг төсөл 100%-ийн гүйцэтгэлтэй боловсруулж дууссан бөгөөд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416.1км төмөр замын ажлын зургууд болон магадлалын ерөнхий дүгнэлтүүдийн хуулбарыг тус тус хүргүүлсэн.

5. СУУРЬ БҮТЦИЙН ГАЗАР

Барилга, эрчим хүчний алба:

Барилга эрчим хүчний ангийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж удирдлага чиг үүргээр хангаж ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд ашиглалтын үйл ажиллагаагаар нийт 39 зүйлийн төлөвлөгөө авснаас 65 хувийн гүйцэтгэлтэй байна. Ашиглалтын үеийн техникийн баримт бичиг хөтлөлтийн журнал, актуудын загвар болон эрчим хүчний байгууламжийн тоног төхөөрөмжид үзлэг үйлчилгээ хийх үеийн графикийг тус тус боловсруулсан.

Цогтцэций өртөөний Зэхэлтийн депогийн барилгад Улсын комиссын гишүүдийн үүрэг даалгавар болон дахин засварлаж, ашиглалтын шаардлага хангуулах зорилгоор 2023 оны 2 дугаар сарын 7-ны өдөр захиалагч, ашиглагч, гүйцэтгэгч нарын хамтарсан үзлэгийг зохион байгуулж, үзлэг шалгалтын явцад гарсан зөрчил, дутагдалтай ажлууд болон дулааны улиралд хийж гүйцэтгэх нийт 39 ажилд акт үйлдэж, Зэвсэгт хүчний 339 дүгээр анги 2023 оны 03 сарын 09-ний өдрөөс 2023 оны 06 сарын 15-ны хооронд тухайн ажлуудыг гүйцэтгэж ашиглагчид актаар хүлээлгэн өгсөн.

Зам засварын барилга, уурын зуухны барилгад Улсын комиссын гишүүдийн үүрэг даалгавар болон дахин засварлаж, ашиглалтын шаардлага хангуулах зорилгоор 2023 оны 2 дугаар сарын 7-ны өдөр захиалагч, ашиглагч, гүйцэтгэгч нарын хамтарсан үзлэгийг зохион байгуулж, үзлэг шалгалтын явцад гарсан зөрчил, дутагдалтай ажлууд болон дулааны улиралд хийж гүйцэтгэх нийт 10 ажилд акт үйлдэж, Зэвсэгт хүчний 338-р анги 2023 оны 05 сарын 04-ний өдрөөс 2023 оны 06 сарын 05-ны хооронд тухайн ажлуудыг гүйцэтгэж ашиглагчид актаар хүлээлгэн өгсөн.

6 *Зураг 1. Зэхэлтийн депогийн барилга, зам засварын барилга, уурын зуухны барилга*



Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын дагуух Эрчим хүчний барилга угсралтын ажил дууссантай холбоотойгоор Эрчим хүчний сайдын А/112 тушаалаар байгуулагдсан улсын комисс Цагаансуварга дэд станц, Зүүнбаян дэд станц, хоёр хэлхээт 35 кВ-ын 455.5 км ЦДАШ Хоорондын замын бааз станц болох АТП маягийн 14 ширхэг 35/0.4 кВ-ын дэд станцуудад ажиллаж, гишүүдийн 100%-ийн саналаар байнгын хүчдэлд залгасан.

Зураг 2. Эрчим хүчний барилга угсралтын ажил дуусч байнгын хүчдэлд залгасан байдал




Цогтцэций өртөө болон 6 зөрлөгийн генераторын барилгын барилга угсралтын ажилд хяналт хийж, зөвлөмж зөвлөгөө өгч ажлыг бүрэн дуусгасан.

Дээвэр засварын ажлыг “Ризолин” ХХК нь ОХУ-д үйлдвэрлэсэн Ризолин Фса дээврийн ус чийг тусгаарлах хуйлмал цаасаар 1 үе нааж уг ажлыг 2023 оны 5 дугаар сарын 25-ны өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 28-ны өдрүүдийн хооронд бүрэн хийж гүйцэтгэсэн.

Хулангийн шанд буюу 6 дугаар зөрлөгийн удирдлагын байранд Зэвсэгт хүчний 339 дугаар анги засвар үйлчилгээ хийж ашиглалтын шаардлага хангуулж хүлээлгэн өгсөн. Мөн Хонгор толгой зөрлөгийн удирдлагын байр, орон сууцны барилгуудыг байнгын ашиглалтад оруулах комисс ажиллаж, гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авсан.

Зураг 3. Өртөө, зөрлөгийн удирдлагын байр



Замын аж ахуйн алба:

Цогтцэций-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн хүрээнд гол замын 416 километр, 6 зөрлөг, Цогтцэций өртөө, Зүтгүүрийн депо, Засварын депогийн замд 82 ширхэг суман шилжүүлэг барьж, арчилгаа үйлчилгээ хийж байна. Төслийн бүтээн байгуулалтын ажил 99,5 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд техникийн комиссоос өгөгдсөн үүрэг даалгаврын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Хүснэгт 1. Техникийн комиссоос өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт

Д/д	Хийгдсэн ажлууд	Хувь
1.	Цогтцэций өртөөний 11, 12, 14-р татах мухар замыг чигжээсээр дүүргэх, өргөж чигжих	100%
2.	Зүтгүүрийн депо, засварын цехийн замын өргөж чигжих, чиг татах, чигжээсээр дүүргэх	100%
3.	Гүүрийн жааз булан төмрөөр хүчжүүлэх ажлаар 21 ширхэг гүүрийг хүчжүүлэх	100%
4.	Гүүрүүд, 3*3м, 4*4м-н хэмжээтэй хоолойнуудад өндрийн хязгаарын тэмдэг хийх /124 ширхэг өндрийн хязгаарын тэмдэг хийсэн/	100%
5.	Мал, амьтны гарцны 2 талд автомашин нэвтрэхийг хориглосон тэмдэг байршуулах /24 ширхэг хориглосон тэмдэг байршуулсан/	100%
6.	Километр зуутуудын шон 2450 ширхэгийг сэргээн засах, тахирын параметрийг тодорхойлсон 250 ширхэг шонг байрлуулах	100%
7.	Өртөө, зөрлөгийн суман шилжүүлэгт шорын 2-р татуурга жааз зам төмөрт нягт шахдаггүй ажлаар 65 ширхэг суман шилжүүлгийн 2-р татуургыг нягт шахсан.	
8.	Өртөө, зөрлөгийн болон гол замыг дарсан элс цэвэрлэх ажлыг 135 километр хийсэн. Цаашид Зүүнбаян-Хулангийн шанд хоорондын замын 30-50-р километр, Архонгилдог-Хонгортолгой хоорондын замын 315-325-р километр, Архонгилдог-Цогтцэций хоорондын замын 370-395-р километрүүдэд дахин цэвэрлэх ажлыг гүйцэтгэхээр төлөвлөж байна.	

Дохиолол холбооны алба:

2023 оны газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дохиолол холбооны чиглэлээр нийт 42 зүйлийн ажил тусгаснаас хагас жилийн байдлаар 65 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна. Мөн Дохиолол холбооны чиглэлээр техникийн комиссоос өгсөн 30 үүрэг даалгаварын биелэлт 90 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын дохиолол төвлөрүүлэлт хориглол ба холбооны байгууламж, 871 км шилэн кабелийг ашиглалтад оруулахад дүгнэлт гаргах техникийн комиссын үүрэг даалгаврын дагуу холбогдох бичиг баримтыг улсын комисст хүлээлгэн өгөхөд бэлтгэн архивын нэгж материал бүрдүүлэн ажиллаж байна.

Цогтцэций өртөө болон зөрлөгүүдийн зам төмөр хэлхээний тусгаарлах уулзварын дугаарлалтын бүдүүвч схемийг зурж батлуулсан.

Ашиглалтын үеийн техникийн баримт бичиг хөтлөлтийн журнал, актуудын загвар, дохиолол холбооны байгууламжийн тоног төхөөрөмжид үзлэг үйлчилгээ хийх үеийн зурмаг, Төмөртэй өртөөний Дохиолол төвлөрүүлэлт хориглолба холбооны байгууламжийн зурмагийг тус тус боловсруулсан. "Дохиолол төвлөрүүлэлт хориглолын байгууламж ашиглах түр заавар"-ыг батлуулж өртөө, зөрлөгүүдэд хүлээлгэн өгч өртөө, зөрлөгүүдийн жижүүр, диспетчер нарт Дохиолол төвлөрүүлэлт хориглолын байгууламж ашиглах түр зааврын талаар сургалтыг зохион байгуулсан.

Зураг 4. Боловсруулсан ашиглалтын үеийн баримт бичгүүд



Дохиолол холбооны эд хөрөнгийн түрээсийн тарифыг Гүйцэтгэх захирлын 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/73 тоот тушаалаар баталсан.

"Тавантолгой-Зүүнбаян" чиглэлийн төмөр замыг элсний нүүдлээс хэрхэн сэргийлэх талаар гадаад, дотоодын төмөр замын байгууллагаас туршлага судалж, хэрхэн сэргийлэх талаар шийдэл гарган цаашид авах арга хэмжээний талаар саналыг боловсруулсан.

Ажлын хэсэгт орж ажилласан байдал:

- Гүйцэтгэх захирлын 2023.02.06-ны өдрийн А/08 тоот тушаалаар батлагдсан Тавантолгой - Зүүнбаян чиглэлийн 416,1 км төмөр замын суурь бүтэц барих төслийн хүрээнд хийгдсэн ажлуудыг хүлээн авах, төмөр замын суурь бүтцийн бүтээн байгуулалтыг Улсын комисст хүлээлгэн өгөхөд шаардлагатай төслийн иж бүрэн баримт бичгийн бүрдлийг хангах, нэгтгэх үүрэг бүхий ажлын хэсэг.
- Гүйцэтгэх захирлын 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/41 тоот тушаалаар батлагдсан Автотээврийн хэрэгслийн 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын норм, тос, тосолгооны материалын жишиг норм тогтоох үүрэг бүхий ажлын хэсэг.
- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/119 тоот тушаалаар батлагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн барилгын ажлын гүйцэтгэлд хэсэгчлэн ажиллаж техникийн комиссоос

өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг шалган баталгаажуулж, албажуулах ажлыг гүйцэтгэсэн.

- “Суурь бүтцүүдийн хооронд галт тэрэг солилцох технологийн нэгдсэн горим”-ыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг.

- “КОТИ” төслийн хүрээнд Нарийнсухайт-Тавантолгой, Сайншанд-Хөөт чиглэлийн төмөр замын урьдчилсан ТЭЗҮ боловсруулах ажлын хэсэг.

Нэгжийн ажилтнуудын сургалтад хамрагдсан байдал:

- ТЗЗБМА салбарын ажилчдад долоо хоног бүрийн 4 дэх өдөр мэргэжлийн чиглэлийн сургалтыг тогтмол явуулж байна.

- Эрчим хүчний ангийн диспетчер инженер, монтеруудын ашиглалтын инженер нар “УБЦТС” ТӨХК-ийн Аюулгүй ажиллагааны зэрэг олгох 15 хоногийн сургалт.

2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрүүдэд Дохиолол холбооны төслийн ажлын хүрээнд “Korea national railway” компани, “Byucksan power” компаниудаас зохион байгуулсан 3 дугаар шатны практик сургалтад албаны 4 инженер, ангийн бүх ажилтнуудыг хамруулав.

- 2023 оны 5 дугаар сарын 07, 14, 21-ний өдрүүдэд Дохиоллын диспетчер, инженерүүдийн онлайн болон танхим хэлбэрээр зохион байгуулсан Дохиолол холбооны шинэ системийн талаар 12 цагийн сургалтад Борхошуу, Баянбулаг, Архонгилдог зөрлөгийн 4 механикчийг хамруулсан.

6.ТЭЭВЭР ЛОГИСТИКИЙН ГАЗАР

Хөдөлгөөн зохион байгуулалтын хүрээнд:

Цогтцэций өртөө түүний харьяа зөрлөг, Төмөртэй өртөөний галт тэрэгний хөдөлгөөнийг шуурхай зохион байгуулж, хөдөлгөөний аюулгүй байдалд тогтмол хяналт тавин ажиллаж байна. Галт тэрэгний хөдөлгөөний гүйцэтгэлийн зурмагийг өдөр тутам журмын дагуу тогтсон цагуудад хүлээн авч бүртгэн, түүнд дүн шинжилгээг хийж удирдлагыг мэдээллээр ханган ажиллаж байна.

Цогтцэций-Зүүнбаян, Цагаан-цав, Тавантолгой чиглэлийн "Галт тэрэгний хөдөлгөөний гүйцэтгэлийн зурмаг хөтлөх журам"-ыг боловсруулсан.

“МТЗ” ТӨХК - “Тавантолгой төмөр зам” ХХК, “МТЗ” ТӨХК - “МТЛ” ХХК-ийн төмөр замуудын хооронд “Галт тэрэг солилцох технологийн түр горим”-ыг боловсруулж батлуулсан.

Галт тэрэгний хөдөлгөөний ахлах диспетчер мөрдөх "Хоногийн төлөвлөгөөт зурмагийг зохиож мөрдөх журам"-ыг боловсруулж байна.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын ачаа тээврийн мэдээ болон галт тэрэг солилцооны мэдээг өдөр бүр 17 цагийн байдлаар мэдээг нэгтгэн боловсруулж компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, Зам, тээврийн хөгжлийн яаманд илгээн ажиллаж байна.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замд галт тэрэгний хөдөлгөөн, ачилт, буулгалт, өдөр тутмын үйл ажиллагааны, ачилтын тайлан тооцооны дараах мэдээллүүдийг 17 цагийн байдлаар өдөр бүр хүлээн авч, боловсруулан сар бүрийн 15, 30-ны өдөр нэгтгэн ГТХЗНТ-д цахимаар хүргүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Ачилт буулгалтын мэдээ
- Галт тэрэг, вагон солилцооны мэдээ
- Тайлант хоногийн хилээр хүлээн авсан, хүлээлгэн өгсөн вагоны мэдээ, үлдэгдлийн мэдээ
- Суурь бүтэц хоорондын галт тэрэг солилцооны хоногийн мэдээ

2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замаар **556,883.109** тонн, Төмөртэй-Хандгайт чиглэлийн төмөр замаар **137,807** тонн ачаа тус тус тээвэрлээд байна. Үүнд:

Хүснэгт 2. Тавантолгой- Зүүнбаян чиглэлийн төмөр замаар тээвэрлэсэн ачаа тээвэр

Д/д	Тээвэрлэлт	Вагоны тоо	Ачсан нийт дүн /тонн/
1.	Экспорт /Зүүнбаян/	150	9301.170
2.	Экспорт /Ханги/	4210	260449.500
3.	Орон нутаг	648	40398.460
4.	Мидлинг	2525	162994.160
5.	Шатахуун	299	18386.977
6.	Ханги төслийн ачаа	560	27744.182
Цогтцэций өртөөний буултын мэдээ:			
7.	Төслийн буулт	102	7502
8.	Хоосон чингэлэг	1162	6504.950
9.	Аж, ахуйн буулт	25	823.620
Тавантолгой өртөөний буултын мэдээ:			
10.	Хоосон чингэлэг	4161	22778.090
Нийт дүн		13842	556,883.109

Хүснэгт 3. Төмөртэй- Хандгайт чиглэлийн төмөр замаар тээвэрлэсэн ачаа тээвэр

Д/д	Тээвэрлэлт	Вагоны тоо	Ачсан нийт дүн /тонн/
1.	1 дүгээр сар	350	24.157
2.	2 дугаар сар	300	20.700
3.	3 дугаар сар	350	24.150
4.	4 дүгээр сар	250	17.250
5.	5 дугаар сар	400	27.450
6.	2023.06.20-ны өдрийн байдлаар	350	24.100
Нийт дүн		2000	137,807

Цогтцэций өртөө, Хонгортолгой зөрлөг, Архонгилдог зөрлөг, Баянбулаг зөрлөг, Хунхарзаг зөрлөг, Борхошуу зөрлөг, Цагаанцав зөрлөг, Хулангийн шанд зөрлөгийн техник захирамжийн актуудыг боловсруулсан. Цогтцэций - Зүүнбаян чиглэлийн төмөр замын дохиолол төвлөрүүлэлт хориглолын байгууламж бүрэн ашиглалтад орж, улсын комисс хүлээн авсны дараа мөрдөх техник захирамжийн акт батлагдсан.

2023 оны "МТЗ" ТӨХК-ийн галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагийг хоногт 6 хос галт тэрэг төлөвлөн боловсруулсан.

"МТЗ" ТӨХК, "ТТЗ" ХХК хооронд галт тэрэг солилцох технологийн түр горимыг шинэчлэх ажлын хүрээнд Монгол Улсын Зам тээврийн хөгжлийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн баталсан "Суурь бүтэц хооронд ачаа солилцох, дамжин өнгөрөх тээвэрлэлтийг зохион байгуулах түр журам"-ын 3.2, тус журмын "Суурь бүтэц хооронд ачаа солилцох гэрээний үлгэрчилсэн загвар"-ын дагуу "МТЗ" ТӨХК болон "ТТЗ" ХХК-ийн хооронд суурь бүтэц хооронд галт тэрэг солилцох, ачаа, хөдлөх бүрэлдэхүүн хүлээлцэх гэрээний төслийг хоёр талын холбогдох албан тушаалтнууд хамтран боловсруулж эцэслэсэн батлуулахаар хүлээгдэж байна.

Шивээхүрэн - Сэхэ чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-д мэргэжлийн холбогдох тооцоо /тээх, нэвтрүүлэх чадвар, боловсруулах чадвар/-г боловсруулж, холбогдох саналыг тусган 05 дугаар сарын 09, 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдрүүдэд Зам, тээврийн хөгжлийн

яамны Шинжлэх ухааны зөвлөлд 2 удаа хамгаалж Шивээхүрэн - Сэхэ чиглэлийн төмөр замын ТЭЗҮ дэмжигдсэн.

Цогтцэций - Зүүнбаян чиглэлийн төмөр замын автомажуулагдсан галт тэрэгний биечилсэн хуудасны хөтлөлтөд хяналт тавих, заавар зөвлөмж өгч ажиллах ажлын хүрээнд шинэчлэгдсэн галт тэрэгний биечилсэн хуудасны хөтлөлтөд хяналт тавьж ажиллаж, алдаа дутагдлыг цаг тухай бүрт нь засч сайжруулж ажилласан.

Цогтцэций-Зүүнбаян чиглэлийн 416.1км төмөр замаар зорчигч тээвэр аялуулахад шаардагдах хөрөнгө оруулалт, тулгамдаж буй асуудал, тус чиглэлийн өртөө зөрлөгүүдийн мэдээ, мэдээллийг нэгтгэн боловсруулж Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн.

Ачаа тээврийн алба:

Ачаа тээврийн үйл ажиллагааны оновчтой зохион байгуулалт, тээвэрлэж буй ачааны бүрэн бүтэн байдалд тогтмол хяналт тавьж, удирдлагыг мэдээллээр хангах, тээвэрлэлтийн гэрээний дагуу ачаа урсгалыг оновчтой болгох, тээвэрлэлтийн найдвартай байдал, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдал, аюултай ачааны ачилт буулгалт болон тээвэрлэлтийн үед холбогдох бичиг баримтын хөтлөлт, аюултай ачааны хадгалалт нь зохих дүрэм журмын дагуу хийгдэж буй эсэхэд хяналт тавьж ажиллаж байна. Компанийн эзэмшлийн ачааны 215 хагас, 10 битүү, 50 тавцант, 57 хоппер вагонуудын замын байдалд өдөр тутам хяналт тавин ажиллаж байна.

“УБТЗ” ХНН-тэй байгуулсан ТТГ/20/19 / Тэг-20/26-25/02 тоот “Ачаа тээврийн үйлчилгээний цахим систем программаар бичиг баримт цахим хэлбэрээр солилцох гэрээний нэмэлт гэрээ”-ний хугацаа 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөр дуусгавар болсон тул гэрээний хугацаа сунгах хүсэлтийг 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01/292 дугаартай албан бичгээр, гэрээ дүгнэсэн акт, нэмэлт гэрээний төслийг цахимаар тус тус хүргүүлсэн бөгөөд гэрээг талууд баталгаажуулсан. Гэрээний хүчинтэй хугацаа 1 жил.

Цогтцэций өртөөг Гаалийн хяналтын бүсээр зарлуулах, тээвэрлэлтийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах үүднээс Гаалийн тухай хууль, Гаалийн Ерөнхий газрын даргын 2022.12.12-ны өдрийн А/339 дүгээр тушаалаар батлагдсан “Гаалийн хяналтын бүсийн журам”-ын дагуу шаардлагатай хавсралт баримтуудыг бүрдүүлж холбогдох газруудад хүргүүлсэн. Гаалийн ерөнхий газрын мэргэжлийн зөвлөлийн 2023.03.21-ний өдрийн хурлаар хэлэлцэгдэж, ГЕГ-ын даргын 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/46 дугаартай тушаалаар нийт 49.35 га талбайг нүүрс болон төрөл бүрийн бараа ачиж буулгах зориулалттай гаалийн хяналтын бүсээр 3 жилийн хугацаатай тогтоосон бөгөөд “Цогтцэций өртөө - 314060” дугаартай гаалийн кодыг авснаар ААН, байгууллагууд Цогтцэций өртөөнд гаалийн бүрдүүлэлт хийх боломжтой болсон.

Цогтцэций, Төмөртэй өртөөний вагон пүүний өдөр тутмын арчилгаа үйлчилгээг тогтмол хийлгэж, жингийн зөрүү гарахаас урьдчилан сэргийлэн ажиллаж байна. Төмөртэй өртөөний 2, Хандгайт өртөөний 1, нийт вагон жингүүдийн баталгаажуулалтын хугацаа 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрөөр дуусгавар болж байгааг “УБТЗ” ХНН-ийн Техникийн бодлого, стандартчиллын албанд 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 05/308 дугаартай албан бичгийг хүргүүлж, 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдөр Хэмжилзүйн эрх бүхий улсын байцаагч эталон вагоноор баталгаажуулж гэрчилгээг олгосон. Гэрчилгээний хүчинтэй хугацаа 1 жил.

“Монголиан Транс лайн” ХХК-тай “Эзэмшлийн бус хөдлөх бүрэлдэхүүнийг тээвэрт оролцуулах гэрээ”-г “Суурь бүтэц ашиглуулах гэрээ”-тэй нэгтгэн “МТЗ” ТӨХК-ийн суурь бүтцээр “Монголиан Транс лайн” ХХК-ийн эзэмшлийн зүтгүүрээр тээвэр хийх гэрээ”-г байгуулан ажиллаж байна.

“МТЗ” ТӨХК, “Монголиан Транс Лайн” ХХК-уудын хооронд 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр өөрийн эзэмшлийн суурь бүтцийг харилцан ашиглуулах, суурь бүтэц дамжин өөрийн зүтгүүрээр тээвэрлэлт хийх хамтын ажиллагааны гэрээг байгуулсан. Тус гэрээний

дагуу “Монголын төмөр зам” ТӨХК нь Цогтцэций-Ханги хүртэл тээвэрлэлт хийхээр төлөвлөж байна.

2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 05/732 тоот албан бичгээр “МТЗ” ТӨХК, “ТТЗ” ХХК-уудын хооронд байгуулах суурь бүтэц ашиглуулах гэрээний төслийг баталгаажуулж, журмын хэрэгжилтийг ханган хамтарч ажиллах гэрээний төслийг хүргүүлсэн.

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутаг дахь Хандгайт өртөөнд байрлаж буй дагнасан хэрэглээний зам талбайн “Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектын гэрчилгээ”-ний хугацааг сунгуулах хүсэлтийг 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 01/217 тоот албан бичгийг хүргүүлж, Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар гэрчилгээний хугацааг сунгасан.

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутаг дахь Төмөртэй өртөөний “Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектын гэрчилгээ”-ний хугацааг сунгуулах хүсэлтийг 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 01/218 дугаартай албан бичгээр хүргүүлж, Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар гарч гэрчилгээний хугацааг сунгасан.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас ирүүлсэн чиглэлийн дагуу “МТЗ” ТӨХК “Цемент шохой” ТӨХК-ийн технологийн нүүрсийг Цогтцэций-Зүүнбаян чиглэлд “Төмөр замаар ачаа тээвэрлэх гэрээ”-ний төслийг боловсруулж хүргүүлсэн.

“Тавантолгой түлш” ХХК-тай Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд “Сайжруулсан шахмал түлшний түүхий эд /Мидлинг/-ийг тээвэрлэх гэрээний төслийг боловсруулж батлуулсан.

“МТЗ” ТӨХК, “Шунхлай” ХХК-ийн нефтийн бүтээгдэхүүнийг Цогтцэций-Зүүнбаян чиглэлд тээвэрлэх “Төмөр замаар ачаа тээвэрлэх гэрээ” байгуулагдсантай холбогдуулан тус нефтийн бүтээгдэхүүнийг тээвэрлэх цистерн вагоны эзэмшигч болон “Трафтранс” ХХК-тай байгуулах “Эзэмшлийн бус хөдлөх бүрэлдэхүүнийг тээвэрлэлтэд оролцуулах гэрээ”-ний төслийг боловсруулж хүргүүлсэн.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ачааг Цогтцэций-Зүүнбаян чиглэлийн 416,1 км төмөр замаар “Монголиан Транс Лайн” ХХК-тай хамтран тээвэрлэх буюу “МТЛ” ХХК-тай харилцан суурь бүтэц ашиглан тээвэр хийх гэрээний төслийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/37 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Суурь бүтэц хооронд ачаа солилцох, дамжин өнгөрөх тээвэрлэлтийг зохион байгуулах түр журам”-н хүрээнд шинэчилж боловсруулж байна.

Ажлын хэсэгт орж ажилласан байдал:

Төмөр замын салбарт RFID технологи нэвтрүүлэхээр Зам, тээврийн хөгжлийн яамнаас байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллаж байна.

Гүйцэтгэх захирлын 2023 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн А/30 тоот тушаалаар байгуулагдсан “Монгол-Тяньжины Дүнзян тээвэр логистикийн төв” төслийн ажлыг эхлүүлэхийн тулд “Монголиан порт групп” ХХК-ийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх, тус төсөлд хөрөнгө оруулж хамтран ажиллах гадаад, дотоодын компанийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллаж байна.

Гүйцэтгэх захирлын 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/32 тоот тушаалаар байгуулагдсан Компанийн эзэмшлийн вагоныг түрээслэх, хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллаж байна

Гүйцэтгэх захирлын 2023 оны 04 дугаар сарын 11-ний өдрийн А/57 тоот тушаалаар байгуулагдсан Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын 113км-т Цагаанцав зөрлөгт байгуулах дэд төслийн ТЭЗҮ боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллаж байна.

"Суурь бүтэц хооронд ачаа солилцох гэрээ "ТТЗ" ХХК болон "МТЗ" ТӨХК хооронд гэрээ байгуулах ажлын хэсэгт ажиллав.

7. ТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР

Тээврийн хяналтын газар нь Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдал, тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээрх хяналтын системийг Төмөр замын тээврийн тухай хууль болон Төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм, түүнтэй нийцүүлэн гаргасан холбогдох хууль, дүрэм, журам, стандартад нийцүүлэн, Компанийн суурь бүтэц, зам талбай, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд мэргэжлийн чиглэлээр төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн үзлэг, шалгалтуудыг хийж учирч болзошгүй аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, төмөр замын тээврийн аюулгүй, тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангуулах талаар хяналт тавьж ажиллаж байна.

Тээврийн хяналтын газар нь 2023 онд хийж хэрэгжүүлэх 12 заалт бүхий гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулан хэрэгжилтийг тухай бүр хангаж ажиллаж байгаа ба 94%-ийн биелэлтэй ажиллаж байна.

Мөн газрын хэмжээнд Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр сар бүр төлөвлөгөө гарган 89%-ийн биелэлтэй хэрэгжүүлж ажилласан.

График 1. Төлөвлөгөөний биелэлт



7.1. Тээврийн хяналт шалгалтын хүрээнд:

Компанийн суурь бүтэц, зам талбай, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд мэргэжлийн чиглэлээр төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн үзлэг, хяналт шалгалтуудыг Тавантолгой-Зүүнбаян төмөр замын төслийн хяналтыг 7 удаа, Төмөртэй өртөөний тээврийн аюулгүй байдлын хяналтыг 5 удаа, нийт 12 удаагийн хяналт, шалгалтуудыг хийж гүйцэтгэсэн.

- Төлөвлөгөөт үзлэг шалгалтыг 10 удаа хийж 371 үл тохирол
- Төлөвлөгөөт бус үзлэг шалгалтыг 2 удаа хийж 54 үл тохирол

Тайлант хугацаанд нийт 12 удаагийн үзлэг шалгалтаар 425 үл тохирлыг илрүүлж, засуулж арилгуулах арга хэмжээг авч ажилласан.

График 2. Тавантолгой Зүүнбаян чиглэлд хийсэн шалгалт, илрүүлсэн үл тохирол




График 3. Төмөртэй өртөөнд хийсэн шалгалт, илрүүлсэн үл тохирол



Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд чиглэл хариуцсан байцаагч нар тогтмол хяналт тавин ажиллаж өртөө зөрлөг бүрт хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчлийг "Байцаагчийн заалтын дэвтэр"-т тэмдэглэж, биелэлтийг заасан хугацаанд нь засаж хэвийн болгох чиглэлээр гүйцэтгэлийн шалгалтыг тогтмол хийх, үзлэг шалгалтын мөрөөр илэрсэн үл тохирлуудыг засаж хэвийн болгох талаар "Хяналт шалгалтын журам"-ын хүрээ /2.7.5./-нд холбогдох газар, алба, нэгжүүдэд 6 удаа, нийт 59 заалтаар албан шаардлагыг хүргүүлж биелэлтийг хангуулж ажилласан.

7.2. Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдал, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, сахилга хариуцлага, яаралтай авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар албан цахилгаан, дотоод албан бичгүүдийг тухай бүр холбогдох албан тушаалтнуудад хүргүүлж, танилцуулах арга хэмжээг авч ажилласан. Үүнд:

- Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр 8
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах чиглэлээр 1
- Цаг агаарын болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 1
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр 3 буюу нийт 9 цахилгаан, 4 дотоод албан бичгийг тухай бүр нь холбогдох газар, алба, нэгжүүдэд хүргүүлж ажилласан.

"Галт тэрэгний хөдөлгөөний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах сарын аян"-ны хүрээнд "МТЗ" ТӨХК-ийн хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргаж, тайланг 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр ГТХЗНТ-д хүргүүлсэн. Мөн тус аяны хүрээнд ажилчдын мэдлэгээс шалтгаалсан зөрчил дутагдалыг бууруулах чиглэлээр хөдөлгөөнтэй шууд холбоотой 59 ажилтанд сургалт зохион байгуулж ажилчдын техникийн мэдлэгийг дээшлүүлж ажиллалаа.

Галт тэрэгний хөдөлгөөнд гарч буй гологдол, дутагдалын судалгааг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулсан судалгааг гарган дүн шинжилгээг хийж, галт тэрэгний хөдөлгөөнд гарч байгаа нийт гологдолын ихэнхи хувь буюу 76%-г эзэлж байгаа галт тэргэнд мал дайрагдсан гологдол нь малын хориг хашаагүй байдлаас ихээхэн шалтгаалж байгаа талаар таннилцуулгыг боловсруулж, Зам, тээврийн хөгжлийн яаманд хүсэлт хргүүлсэн.

7.3. Замын аж ахуйн чиглэлээр:

Элсэнд дарагдсан хоолойнуудын судалгааг гарган судалгааны дагуу элс шорооноос хамгаалах арга хэмжээг авч ажиллах талаар ТЗЗБМА-д үүрэг чиглэл өгч ажилласан.

"Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх журам"-д тусгах саналыг нэгтгэн боловсруулж 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 02/407 тоот албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яамны ТЗДТБХЗГ-т хүргүүлсэн.

Хаврын шар усны үерээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд 12 заалт бүхий төлөвлөгөөг гарган хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажилласан. 2023 оны 4 дүгээр

сарын 14,15-ны өдрүүдэд Төмөртэй-Хандгайт өртөө хоорондын замын техникийн болон шар усны байдлыг тууш шалгаж холбогдох шаардлагуудыг тавьж ажилласан.

Технологийн авто замаар нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагаа явагдаж байгаагаас үүдэн төмөр замын тээвэрлэлтийн үйл ажилгаанд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа талаар дурьдсан дэмжлэг туслалцаа хүссэн 01/572 тоот албан бичгийг Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн.

7.4. Хөдөлгөөн зохион байгуулалтын чиглэлээр:

“МТЗ” ТӨХК-ний зүтгүүрийн машинч, туслах машинч нарын эмчийн үзлэгийг “УБТЗ” ХНН-ийн Зүүн баян өртөөнд “МТЛ” ХХК хариуцан хийдэг байсныг 2022.12.26-ний өдрөөс эхлэн зогсоосныг “МТЛ” ХХК-тай харилцан тохиролцож ажилтнуудын эмчийн үзлэгийг дахин хийхээр болсон.

7.5. Ачаа тээврийн чиглэлээр:

Цогтцэций, Төмөртэй өртөөнд хөтлөгдөж буй ачаа тээврийн ажилчдын техникийн бичиг баримт хатуу тооцоот бланк /Санамж, ЕМА, замын хүснэгт/-ыг хөтлөхдөө тооцооны оператор АВХ нар буруу хөтлөх зөрчлүүд гарч байгаад 7 хоног бүрээр зөрчлийн судалгааг гарган зөрчлийг арилгах чиглэлээр мэргэжил арга зүйн зөвөлгөөг өгч ажиллаж байна.

Төмөртэй, Цогтцэций өртөө ГЕГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/339 тушаалаар “Гаалийн хяналтын бүс”-ийн журамд өөрчлөлт орсонтой холбогдуулан шинээр батлагдсан журмыг танилцуулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

/Опен топ/ 20 тонн чингэлэгт нүүрс болон төмрийн хүдэр ачих техникийн нөхцөлийг боловсруулан тээвэрлэлтийн үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна.

Олон улсын төмөр замын ачаа харилцааны хэлэлцээр /ОАХХ/,ЦИМ/СМГС-ийн падааны заавар,ОАХХ-ийн албан заавар зэргийг Төмөртэй, Цогтцэций өртөөний ачаа тээврийн ажилчдад судлаж таниулах, сургалтыг зохион байгуулсан.

2023 оны 01 дүгээр сараас Гааль татварын системд өөрчлөлт орж байгаатай холбогдуулан IT инженертэй хамт Цогтцэций өртөөний гаалийн сүлжээ, вагон пүүний программыг ГЕГ-ын болон Гашуун сухайтын гаалийн програмд шинээр холбуулах ажлаар Цогтцэций өртөөн дээрхи пүүний серверийн компьютерийн сүлжээний тохиргоог хийж мөн серверийн компьютерийг форматлаж JSON серверийн холболтыг хийхэд бэлэн болгож ажилласан.

“Би Би Эф”ХХК-ийн Пүүний инженертэй хамтарч серверийн программ хангамжийг суулгаж тохиргоог хийлгэн Gaali.mn системтэй холбоход бэлэн болгосон. Мөн гаалийн ерөнхий газрын программисттай холбогдож Gaali.mn системтэй холбогдож пүүний мэдээллийг татаж авах гэсэн боловч гаалийн талаас холболтууд болохгүй нэмэлт программын хөгжүүлэлт хийх шаардлагатай болсон.

7.6. Дохиолол холбооны чиглэлээр:

Цогтцэций хэсэглэл болон Төмөртэй өртөөний Дохиолол, төвлөрүүлэлт хориглол ба холбооны байгууламж, зурмагт ажилд нормативт үзлэг хийж илэрсэн гэмтэл зөрчлүүдийг арилгах талаар байцаагчын заалтын дэвтэрт хугацаатай үүрэг өгсөн. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын NS-AM маркийн цахилгаан шилжүүлэгчийн 8-н утастын схемийг судлаж ажлын ба хяналтын хэлхээг дэлгэмэл байдлаар зурж гарган, Гүйцэтгэгч компаний инженер техникийн ажилтантай схемийн алдаатай байдлыг үзүүлж засуулах талаар үүрэг чиглэл өгсөн. Тавантолгой-Зүүнбаян төмөр замын ДТХ ба холбооны шинэ байгууламжид тохируулж 4-н долоо хоногийн зурмаг боловсруулж гаргасан.

Тавантолгой-Зүүнбаян төмөр замын хөдөлгөөнтэй холбоотой ажилчдаас ДТХ-н байгууламжийг ашиглах заавраар шалгалт авах материал бэлдсэн.

Тавантолгой-Зүүнбаян төмөр замын Дохиолол, Холбооны ажилтнуудад “Сумын 8-н утастын бүдүүвчийн хяналтын болон ажлын хэлхээ” сэдэвт техникийн сургалтыг зохион байгуулсан.

8. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨЛТ, ТӨСЛИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР

Баруун болон зүүн босоо чиглэлийн төмөр зам, Боомтын төмөр замын төслүүдийн хүрээнд 2023 онд хийгдэх ажлын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 01/143 албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн сайдад хүргүүлж ажлын нарийвчилсан төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төслүүдийн танилцуулгыг тухай бүр шинэчлэн боловсруулж байна.

8.1. Стратеги төлөвлөлтийн хэлтэс

Компанийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн Стратеги төлөвлөлтийн хэлтсийн жилийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

Тайлант хугацаанд бүх газар, нэгжийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг дотооддоо нэгтгэн боловсруулж, нэгдсэн төлөвлөгөөг батлуулсан.

Зам, тээврийн хөгжлийн сайдтай байгуулсан “МТЗ” ТӨХК-ийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний I дүгээр улирал, эхний хагас жилийн биелэлтийг нэгтгэн боловсруулж, Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газарт цаасан суурьт болон цахимаар хэлбэрээр тус тус хүргүүлсэн.

Баруун болон зүүн босоо чиглэлийн төмөр замын төслийн бэлтгэл ажлын нарийвчилсан төлөвлөгөөний биелэлтийг Зам, тээврийн хөгжлийн Дэд сайдад илтгэх хуудсаар тухай бүр хүргүүлж ажилласан.

Компанийн дунд болон урт хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд ажлын төлөвлөгөөний төслийг боловсруулж Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад хүргүүлсэн. Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн зөвлөмжийн дагуу Компанийн урт дунд хугацааны стратеги боловсруулж ажиллаж байгаа бөгөөд Санхүү, эдийн засгийн дээд сургуультай хамтран стратеги төлөвлөлтийн сүүлийн үеийн арга туршлагын талаар зөвлөмж авч, холбогдох судалгааны ажлыг хийж байна.

“Монголын төмөр зам” ТӨХК -ийн 2023 оны бизнес төлөвлөгөөг боловсруулах ажлын хүрээнд дараах дэлгэрэнгүй судалгааг боловсруулсан: Үүнд:

- Компанийн танилцуулга, байгууллагын зорилго, зорилтуудыг тодорхойлох
- Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах
- Газар, нэгжүүдээс ирсэн баримт бичигт дүн шинжилгээ хийх, санал боловсруулах
- Гадаад болон дотоод орчны шинжилгээ, үр дүн
- Улстөр, хууль эрхзүйн орчны, Эдийн засгийн орчны, Нийгэм, соёлын орчны, техник, технологийн орчны, Хүрээлэн байгаа орчны, Гадаад орчны нөлөөллүүд
- Зах зээлийн боломж, Өрсөлдөөний орчин, салбарын зохицуулалт, бэлтгэн нийлүүлэгч
- Төмөр замын бүтээн байгуулалт, төмөр замын суурь бүтэц ашиглалт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа, шинээр төмөр зам барих төсөл хөтөлбөрүүд, компанийн хөгжлийн хэтийн төлөв
- Байгууллагын хүний нөөцийн төлөвлөгөөг боловсруулах
- Санхүүгийн төлөвлөгөөг боловсруулах

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу “Монголын төмөр зам” ТӨХК -ийн 2024-2026 оны зорилтын саналыг батлагдсан маягтын дагуу боловсруулж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын удирдлага зохицуулалтын хэлтэст хүргүүлж ажилласан.

Төсөл хөтөлбөр:

Баруун болон Зүүн босоо чиглэлийн төмөр замын төслүүдэд хөрөнгө оруулж, хамтран ажиллахаар санал ирүүлсэн “Эссенз Саплайз” ХХК-ийн төлөөллүүдтэй хамтын ажиллагаа, хувьцаа эзэмшигчдийн гэрээний талаар санал солилцох уулзалтыг тухай бүр зохион байгуулж ажилласан.

Боомтын төмөр замын төслийн хүрээнд Шивээхүрэн-Сэхээ боомтын төмөр замын Техник, эдийн засгийн үндэслэлийн хөрөнгө оруулалтын тооцооллыг урьдчилсан байдлаар боловсруулсан.

Баруун босоо чиглэлийн төмөр замын төслийн ажлын хэсэгт эдийн засгийн тооцооллын дэмжлэг үзүүлж, Хөрөнгө оруулалтын харьцаа болон мега төслүүдийн хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах жишгийн талаар санал өгсөн.

Замын-Үүд Бүс нутгийн логиستيкийн төвийн үйл ажиллагааны танилцуулга боловсруулахад эдийн засгийн тооцооллын дэмжлэг үзүүлсэн.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын 113км-т Цагаанцав зөрлөг /өртөө/ байгуулах дэд төслийн Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллаж байна.

Компанийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх дэвшилтэт технологи, инновацийн судалгаа:

Мал, амьтныг төмөр зам руу орохоос хамгаалах олон улсын туршлага, дэвшилтэт технологийн судалгааг англи хэл рүү хөрвүүлж бэлэн болгосон.

Польш улсын “Neel” компанийн “UOZ” акустик төхөөрөмжийг нарийвчлан судалж, танилцуулгыг боловсруулсан.

Төмөр замын ачаа тээврийн нэгдсэн платформтой болгох чиглэлийг Зам, тээврийн хөгжлийн яамнаас өгсний дагуу e-logistic болон RFID-г хөгжүүлэгч “ДАЗО” ХХК-ийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж “Монголын төмөр зам” ТӨХК нь RFID-г ашиглах судалгааг гаргаж холбогдох инженер техникийн ажилтнууд болон менежерүүдээс санал авч ажиллаж байна.

Төслийн удирдлагын мэдээллийн систем нэвтрүүлэх ажлын хүрээнд “Интерактив” ХХК-ийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж урьдчилсан саналыг танилцуулсан.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийг Улсын комисст хүлээлгэн өгөх ажлын хүрээнд:

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийг Улсын комисст хүлээлгэн өгөх, УИХ-ын сонсголоор хэлэлцэхэд ашиглагдах Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн ажлыг хийж гүйцэтгэсэн нийт 120 гаруй компаниудын бичиг баримтыг цэгцэлж, бэлэн болгон төслийн ажлыг гүйцэтгэгч компаниуд, төслийн гүйцэтгэлийн талаар холбогдох танилцуулгыг тус тус боловсруулсан.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн үлдэгдэл санхүүжилт болох 103,8 тэрбум төгрөгөөс 5 тэрбум төгрөг “ЭТТ” ХК-аас шилжин орж ирсэн бөгөөд зарцуулалтын тайланг Зам, тээврийн хөгжлийн яам, “ЭТТ” ХК-д тус тус хүргүүлэн ажиллаж байна.

8.2. Баруун болон зүүн босоо чиглэлийн төмөр замын төсөл

Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн, Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын суурь бүтэц барих Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах ажлын даалгаварт Зам, тээврийн хөгжлийн яамны саналыг тусган боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргаар 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдөр батлуулсан.

“Шинэ сэргэлтийн бодлого”-ийн Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын төслийн хүрээнд тусгагдсан арга хэмжээний биелэлтийг Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газарт 2023 оны 03 дугаар сарын 29-ны өдөр цахимаар хүргүүлсэн.

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвөлийн 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 23/11 дүгээр тогтоолоор “Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн төмөр зам” ХХК, “Чойбалсан-Хөөт-Бичигт төмөр зам” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн гэрээ байгуулах эрхийг Гүйцэтгэх захиралд олгосоны дагуу 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдөр гэрээ байгуулсан бөгөөд “Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн төмөр зам” ХХК,

“Чойбалсан-Хөөт-Бичигт төмөр зам” ХХК-ийг Улсын бүртгэлд бүртгүүлэхээр холбогдох баримт бичгийг бэлтгэн ажиллаж байна.

Гадаад харилцааны яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Хөрөнгө оруулалтын судалгааны төв, Далайн захиргаа хамтарсан “Хуурай боомтыг хөгжүүлэх замаар хил дамнасан дамжин өнгөрөх тээврийн үр ашгийг дээшлүүлэх, чадавхийг бэхжүүлэх санаачилгууд” уулзалтад 2023 оны 06 дугаар сарын 20-21-ны өдрүүдэд Баруун босоо чиглэлийн төмөр замын төслийн менежер оролцсон.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 01/2484 тоот Сайншанд-Баруун-Урт-Хөөт чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх тогтоолын хэрэгжилтийг хангах чиглэлийн дагуу ажиллаж байна.

Баруун босоо чиглэлийн төмөр замын төслийн нээлтийн үйл ажиллагааг 2023 оны 06 дугаар сард багтаан зохион байгууллахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

8.3. Боомтын төмөр замын төсөл

Шивээхүрэн-Сэхээ, Бичигт-Зүүнхатавч боомтын төмөр замуудын Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийн ажлын даалгаврыг боловсруулсан.

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 23/04 тоот тогтоолыг үндэслэн “Монголын төмөр зам” ТӨХК - 51 хувь, “Нарийнсухайтын төмөр зам” ХХК – 49 хувийн оролцоотой “Шивээхүрэн төмөр зам” ХХК-ийг 2023 оны 03 сарын 01-ний өдөр байгуулсан. Компанийн дүрэм болон хувьцаа эзэмшигчдийн гэрээг боловсруулсан.

Шивээхүрэн боомтын төмөр замын төслийн Техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж Зам, тээврийн хөгжлийн яамны ШУТЗ-ийн 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж дэмжигдсэн бөгөөд хээрийн судалгааны ажилд хамаарах инженер геодези, инженер-геологи, геотехник, гидрологи, археологийн судалгааны ажлуудыг “Нарийнсухайтын төмөр зам” ХХК-аар гүйцэтгүүлж, ажлын тайланг хүлээн авсан. Мөн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг гүйцэтгүүлэн Байгаль орчин, аялал жуулчлалын яамаар батлуулахаар хүргүүлсэн.

Шивээхүрэн хил дамнасан төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл, барилгын ажлын зөвшөөрөл олгох Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан, ЗТХЯ-тай хамтран ажиллаж “Шивээхүрэн хил дамнасан төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл, барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрөл”-ийг Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 186 тоот тогтоолоор “Нарийнсухайтын төмөр зам” ХХК-д олгосон. Үүний дагуу 2023 оны 06 дугаар сард Шивээхүрэн-Сэхээ боомт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн.

“Нарийнсухайтын төмөр зам” ХХК-ийн захиалгаар БНХАУ-ын “Төмөр замын зураг төслийн корпораци”-ийн /CRDC/ боловсруулж ирүүлсэн “Шивээхүрэн-Сэхээ” боомтын төмөр замын нарийвчилсан зураг төслийг хүлээн авч Зураг төслийн албатай хамтран хяналт тавьж, магадлуулахад бэлэн болгов.

Шивээхүрэн боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх талаар Хятадын төмөр замын байгууллагуудтай хэлэлцээ хийх ажлын хүрээнд 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдөр Зам, тээврийн хөгжлийн яам, БНХАУ-ын Улсын төмөр замын газар хооронд газрын дарга нарын түвшинд цахим хурлыг зохион байгуулж, Хятадын талаас “Хятадын төмөр замууд” корпораци хариуцахаар томилогдсон. Үүний дагуу “Хятадын төмөр замууд” корпорацитай хэлэлцээрийн тохиролцох асуудлууд, удирдамж, протоколын төслийг боловсруулж, Зам, тээврийн хөгжлийн сайдад хүргүүлсэн бөгөөд Монгол, Хятадын хилийн Шивээхүрэн-Сэхээ, Бичигт-Зүүнхатавч боомтуудын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын талаар хятадын талтай хийх яриа хэлэлцээрийн удирдамжийг баталж ирүүлсэн.

2023 оны 05 дугаар сарын 23-27-ны өдрүүдэд “Хятадын төмөр замууд” корпорацитай уулзалт зохион байгуулсан. Уулзалтаар Шивээхүрэн-Сэхээ, Бичигт-Зүүнхатавч хилийн

боомтуудын холболтын төмөр замын төлөвлөлтийн талаар танилцуулга хийж, хил дамнасан төмөр замын техникийн нөхцөл, бүтээн байгуулалтын талаар Хятадын талтай тохиролцох асуудлуудыг танилцуулсан. Үүнд:

- 2016 оны Монгол Улсын ГХЯ, БНХАУ-ын ГХЯ-ны ажлын хэсэг, хоёр талын мэргэжлийн байгууллагууд газар дээр нь ажиллаж тогтоосон хил огтлолын цэгээр нарийн болон өргөн царигийн хос төмөр замаар холбох,
- Монголын тал эхний ээлжинд Шивээхүрэн, Бичигт боомтуудын нарийн царигийн төмөр замыг хоёр улсын тохиролцсон хил огтлолын цэг хүртэл барих,
- Хятадын тал Сэхээ болон Зүүнхатавч төмөр замын өртөөнөөс хоёр улсын тохиролцсон хил огтлолын цэг хүртэл төмөр замыг үргэлжлүүлэн барих,
- Хилийн өртөөнд хоёр төмөр замын хооронд галт тэрэг солилцоо, ачаа тээврийн технологийн ажиллагааг тохиролцох,
- Шивээхүрэн-Сэхээ, Бичигт-Зүүнхатавч боомтын хил дамнасан нарийн царигийн төмөр замаар нүүрс экспортлох,
- Монголын талаас өргөн царигийн төмөр замыг барьж ашиглалтад оруулсан үед Олон улсын ачааны харилцааны хэлэлцээр /СМГС/-ийн дагуу төмөр замуудын үйл ажиллагааг зохицуулах,

Хятадын тал тавьсан саналуудыг нааштайгаар хүлээн авч дэмжиж ажиллахаа илэрхийлээд уг асуудлуудын хүрээнд талууд харилцан санал солилцож, дараах асуудлуудад санал нэгдэв. Үүнд:

- “Монголын төмөр зам” ТӨХК, “Хятадын төмөр замууд” корпорацийн хоорондын харилцааг цаашид улам бэхжүүлж, түргэн шуурхай болгох,
- Хятадын тал тавьсан саналуудыг ойрын хугацаанд судалж, холбогдох саналуудыг боловсруулж Монголын талтай санал солилцох,
- ХТЗ корпораци Монголын талын тавьсан саналуудад дүгнэлт гаргаж Хятадын “ХШХ” болон “Хятадын Улсын төмөр замын газар”-т танилцуулж холбогдох шийдвэрийг шуурхай авах,
- “Монголын төмөр зам” ТӨХК, “Хятадын төмөр замууд” корпорацийн хоорондын хамтын ажиллагааны баримт бичгийг 2 талын удирдлагын түвшинд байгуулах,
- “Монголын төмөр зам” ТӨХК, “Хятадын төмөр замууд” корпорацийн дараагийн уулзалтыг Монгол Улсад зохион байгуулах.

Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан ажлын даалгаврын дагуу Бичигт-Зүүнхатавч боомтын төмөр замын Техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж байгаа бөгөөд инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг “Ийст корридор рэйлрүүд” ХХК-д хүргүүлсэн. “Ийст корридор рэйлрүүд” ХХК-тай Бичигт боомтын төмөр замын хээрийн судалгааны ажлыг хариуцан гүйцэтгэх тухай санамж бичгийг байгуулсан. Санамж бичигт геологи, геодези, гидрогеологи, түгээмэл тархацтай ашигт малтмал, архелоги, палеонтологи, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон төслийн бэлтгэл ажилд шаардлагатай бусад ажлуудыг хийж гүйцэтгэхээр тусгасан.

9. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ, БАЙГАЛЬ ОРЧНЫ АЛБА

Тавантолгой Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөлд Техникийн комиссоос байгаль орчны чиглэлээр өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн бөгөөд үүрэг даалгаврын биелэлт 68.2%-тай байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийг Гүйцэтгэх захирлын 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/45 тоот тушаалаар баталж, Цогтцэций, Төмөртэй өртөө, зөрлөгийн ажилтнуудад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, ХАБЭА-н хуулийн талаар холбогдох сургалтыг зохион байгуулж ажилласан.

MNS4969:2000 стандартын дагуу нийт ажилтнуудад шууд удирдлагаар дамжуулан Хөдөлмөрийн аюулгүй байдлын өдөр тутмын зааварчилгааг өгч, өдөр тутмын зааварчилгааны дэвтэрт тэмдэглэл хөтлүүлэн ажиллаж байна. Ээлжит давтан зааварчилгааг улирал бүр газар, алба, нэгжийн удирдлагууд ажилтнуудад өгч ажиллаж байна. Ээлжит бус давтан зааварчилгааг ХАБЭА-н албанаас тухай бүр өгч ажилласан.

Нийт ажилтнуудын эрүүл, аюулгүй ажиллах нөхцлийг бүрдүүлэх, ХАБЭА-н тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор тайлант хугацаанд хөдөлмөр хамгааллын хувцсыг 440 ажилтанд олгож, нэг бүрийн хамгаалах хэрэгслийг нэн шаардлагатай байгаа 250 ажилтан /өвдгөвч, тохойвч, дуулга, нүдний шил дарцаг, гар чийдэн гэх мэт/-д хүлээлгэн өгсөн.

Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газартай 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдөр хамтран ажиллах санамж бичиг үзэглэсэн. Санамж бичгийн хүрээнд тус сангийн санхүүжилтээр Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замд хийгдсэн гүүр, хоолой болон мал, амьтны гарцууд дээр зэрлэг амьтны хөдөлгөөн, нүүдэл, шилжилтийн мониторинг хийх зорилгоор нийт 156 хөдөлгөөн мэдрэгч автомат камер суурилуулсан. Автомат камерыг суурилуулснаар шугаман дэд бүтцийг мал, зэрлэг амьтдад ээлтэй байдлаар төлөвлөх, хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулахад шаардлагатай дата мэдээлэлтэй болох боломжийг бүрдүүлж байна.

“Монголын төмөр зам” ТӨХК нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдсэн цагаас Улаанбаатар хот болон “Тавантолгой-Зүүнбаян” чиглэлийн төмөр замын өртөө, зөрлөгүүдэд 10,030 гаруй модны суулгац тариад байна.

Хүснэгт 4. “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд тарьсан мод

Д/д	Огноо	Байршил	Тоо хэмжээ, ш
1	2021-04-25	Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөл /Зөрлөг 2/	200
2	2021-10-02	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг	50
3	2021-10-09	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, Баруун салаа, Бумбатын рашаан	100
4	2022-05-13	Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөл /Өртөө, зөрлөгүүд/	1,000
5	2022-05-20	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, Баруун салаа, Бумбатын рашаан	50
6	2022-10-14	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, Ар гүнт, Инчон мөрөөдлийн төгөл төсөл	150
7	2022-05-13	Улаанбаатар хот, Өлзийт хороолол, Хөшигийн хөндийн авто зам	100
8	2023-05-26	Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам, Цогтцэций өртөө	2,000
9	2022-06-04	Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөл /Цогтцэций өртөө/	1,702
10	2022-05-19, 2022-10-24	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, Баруун салаа, Бумбатын рашаан	130
11	2022-05-20, 2022-10-25	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, "Баянгол цэцэрлэгт хүрээлэн" ОНӨҮГ, "Зүүнбаян төгөл"	4,548
Нийт			10,030

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьц, суулгацын нөөц бүрдүүлэх зорилгоор “Агро форест” ХХК-тай 33,000 модны суулгац нийлүүлэх гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Хөшигийн хөндийн хурдны зам дагуу Өлзийт хороололд 200 ширхэг мод, Цогтцэций өртөөнд 2000 ширхэг мод суулгав.

Зураг 5. 2023 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Үндэсний мод тариалах өдрөөр



Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аян:

“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аян 2023”-ны хүрээнд Цогтцэций зангилаа, Төмөртэй өртөөний зам паркаар явах аюулгүйн замналыг боловсруулан баталгаажуулж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн булан, ажлын өрөө тасалгааны тохижилтыг сайжруулж ажилласан. ХАБЭА-н хуулийн талаар “АХА” тэмцээнийг ажилтнуудын дунд зохион байгуулж, ажилтнуудын эрүүл, идэвхитэй амьдралын хэв маяг, эрүүл мэндэд анхаарч спорт заал түрээсийн гэрээ байгуулж ажиллав.

Зураг 6. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аян 2023”



Галын аюулгүй байдал, Гамшгаас хамгаалах сургалт

Цогтцэций зангилааны өртөө, зөрлөгт галын аюулгүй байдал, анхны түргэн тусламжийг үзүүлэх сургалтыг Өмнөговь аймгийн Онцгой байдлын газартай хамтран зохион байгуулж нийт 263 ажилтныг хамруулсан. MNS 5566:2020 стандартын дагуу аж ахуйн нэгж байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, нормын дагуу Цогтцэций зангилааны өртөө, зөрлөгт 4кг-н галын хор 82ш, 20кг-н галын хор 2ш, бие даан гал унтраах төхөөрөмж 19 ширхэгийг тус тус байршуулав.

Зураг 7. Гамшгаас хамгаалах сургалт (2023.05.08)



ХАБЭА-н зөвлөл, ҮОХХ-г судлан бүртгэх комисс:

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Гүйцэтгэх захирлын 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/16 тоот тушаалаар шинэчлэн баталсан. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус “Комисс бүрэлдэхүүн”-ийг Гүйцэтгэх захирлын 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/15 тоот тушаалаар шинэчлэн баталж, хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ хийлгэх шаардлагатай ажлын байрны талаар 2 удаа хуралдаж нийт 68 төрлийн 423 ажлын байранд хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ хийлгэх шийдвэр гарсан.

10. ГАДААД ХАРИЛЦАА, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ АЛБА

Компанийн үндсэн үйл ажиллагаа болон хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийг нийтийн мэдээллийн ил тод байдлын хуульд нийцүүлэн контентын бүх төрлөөр бэлтгэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээх, олон нийтэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах, гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллагатай харилцаа холбоо, хамтын ажиллагааг өргөтгөн нэмэгдүүлэх, Засгийн газрын бодлого, шийдвэрийг компанийн үйл ажиллагаагаар төлөөлүүлэн контентын бүх төрлөөр бэлтгэн олон нийтэд хүргэх чиглэлээр ажиллаж байна.

Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд:

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хүрээнд “Монголын төмөр зам” ТӨХК-ийн www.mtz.mn цахим хуудсаар цаг үеийн мэдээ мэдээллийг тухай бүр шинэчлэн нийтэлж, компанийн цахим хуудсыг шинэчилж, тодорхой тооны мэдээллүүдийг Англи хэл дээр хөтлөн ажиллаж байна.

Сошиал медиа:

“Монголын Төмөр Зам” пэйж хуудсанд тайлант хугацаанд цаг үеийн үйл явдал, танин мэдэхүй, үндсэн үйл ажиллагаатай холбоотой 59 удаагийн постер, мэдээллийг тухай бүр бэлтгэн нийтэлсэн бөгөөд “Монголын Төмөр Зам” пэйжийн дагагчийн тоо 19.1К-д хүрсэн.

Хамтын ажиллагаа, олон нийтийн арга хэмжээ:

2023 оны 02 дугаар сарын 06-ны өдөр “ОХУ, Монгол улс, БНХАУ-ын ачаа тээврийн хэлэлцээр” цахим хуралд оролцож Боомтын төмөр замын төслүүдийн талаар танилцуулж ажилласан.

2023 оны 02 сарын 07-ны өдөр Зам, тээврийн хөгжлийн сайд “Тяньжин порт групп” ХК-ийн төлөөлөгчид болон “Монголиан порт групп” ХХК-ийн төлөөллийг хүлээн авч уулзсан уулзалтад оролцов.

China Railway Design Corporation (CRDC) Гадаад дахь бизнесийн хэлтсийн Ерөнхий менежерийн орлогч ахлах инженер тэргүүтэй төлөөлөгчидтэй “Монголын төмөр зам” ТӨХК-ийн удирдах албан тушаалтнууд уулзалт зохион байгуулж боомтын төмөр замын зураг төслийн явц, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцсон.

“МТЗ” ТӨХК нь “Монголын газрын тосны бүтээгдэхүүн импортлогчдын мэргэжлийн холбоо”-той Зүүнбаян-Тавантолгой чиглэлийн төмөр замаар шатахуун тээвэрлэлтийн үйл ажиллагаа зохион байгуулахаар хамтран ажиллах “Санамж бичиг” үзэглэв.

Зураг 8. Хамтран ажиллах санамж бичиг үзэглэв. (2023.02.17-ний өдөр)



2023 оны 03 дугаар сарын 15-ны өдөр Хятадын Харилцаа, холбооны бүтээн байгуулалтын Корпорацийн Нэгдүгээр боомтын бүтээн байгуулалтын Хязгаарлагдмал компани (CCCC First Harbor Engineering Co.,Ltd)-тай уулзсан уулзалтад оролцов..

2023 оны 03 дугаар сарын 23-ны өдөр Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн зохион байгуулсан “Төмөр замын дотоодын сүлжээний суурь бүтцүүдээр дамжин өнгөрөх ачааны хэмжээг тохиролцох, ачаа тээвэрлэлтийг зохион байгуулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх зөвлөгөөн”-д оролцов.

Зам, тээврийн хөгжлийн яам, Солонгосын KOTI байгууллагын хамтран зохион байгуулсан “Зүүн Азийн төмөр замын холболтыг бэхжүүлэх тухай олон улсын семинар”-т оролцов.

Зураг 9. “Зүүн Азийн төмөр замын холболтыг бэхжүүлэх тухай олон улсын семинар”.
(2023.04.05-ны өдөр)



2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр АНУ-ын Тээврийн Яамны Олон улсын тээвэр, худалдааны албаны Ази, Номхон далайн ахлах менежер, Холбооны төмөр замын захиргааны Олон улсын хөтөлбөрийн захирал, Холбооны төмөр замын захиргааны Судалгаа хөгжил, технологийн албаны Судалгааны хөтөлбөрийн менежер, Холбооны төмөр замын захиргааны Төмөр замын аюулгүй байдлын албаны системийн инженер тэргүүтэй хүндэт төлөөлөгчтэй уулзалт зохион байгуулж, АНУ-ын Холбооны Төмөр Замын Захиргааны Аюулгүй байдлын албаны мэргэжлийн чиг үүрэг, хариуцлага, аюулгүй байдлын хяналт шалгалт, хяналт шалгалтыг хэрхэн хийхийг шийдэх эрсдэлийн үнэлгээ, төмөр замын аюулгүй байдал, төмөр замын зохицуулалтын процесс сэдвээр санал солилцсон.

Зураг 10. АНУ-ын Холбооны төмөр замын төлөөлөгчдийн хамт(2023.04.25)



2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр “Монголын төмөр зам” ТӨХК, “Монголиан Транс Лайн” ХХК-иудын хооронд өөрийн эзэмшлийн суурь бүтцийг ашиглуулах, “Монголиан Транс Лайн” ХХК-ийн суурь бүтцийг ашиглах хамтын ажиллагааны гэрээг байгуулав.

2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр Зам, тээврийн хөгжлийн яам, Монгол улс дахь төмөр замын суурь бүтэц эзэмшигчид, тээвэр логикийн үйл ажиллагаа эрхлэгч компаниудыг хамарсан “Логистик форум-2023” зөвлөгөөний “Дэд бүтэц, терминал, төмөр замын нөхцөл байдал” сэдэвт хэлэлцүүлэгт оролцов.

2023 оны 05 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулагдсан “Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны туршлага, мэдээлэл солилцох зөвлөгөөн”-д “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Тээврийн хяналтын газрын байцаагч “Хөдөлгөөний аюулгүй байдлын системийн танилцуулга, хөдөлгөөний аюулгүй байдлын бодлого, аюулгүй байдлыг хангах чиглэлээр хийж хэрэгжүүлж буй ажил” сэдвээр илтгэл тавьж оролцов.

“МТЗ” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал 2023 оны 05 дугаар сарын 27-ны өдөр “Шивээхүрэн-Сэхээ” боомт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын нээлтийн үйл ажиллагаанд оролцсон.

2023 оны 05 дугаар сарын 29-ны өдөр “Дэлхийн оюуны өмчийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан “УБТЗ” ХНН-ээс 10 дахь жилдээ зохион байгуулж буй “Оюуны өмч, Инновацийн үйл ажиллагааны өдөрлөг”-т оролцож “Тавантолгой-Зүүнбаян” чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалт”-ын талаар танилцуулав.

Зам, тээврийн хөгжлийн яам болон МҮХАҮТ-ын хамтран зохион байгуулсан “Шинэ сэргэлтийн бодлого, Зам, тээврийн сэргэлт” уриан дор Зам, тээврийн салбарын хөрөнгө оруулалтын чуулга уулзалтад оролцов.

Зураг 11. “Зам, тээврийн салбарын хөрөнгө оруулалтын чуулга уулзалт (2023.06.09)



Засгийн газрын 2022 оны 116 дугаар тогтоолын дагуу “Монголын төмөр зам” ТӨХК нь Баруун босоо чиглэлийн төмөр замын төслийн хөрөнгө оруулагч “Эссенз саплайз” ХХК, Зүүн босоо чиглэлийн төмөр замын төслийн хөрөнгө оруулагч “Ийст корридор рэйлрөүд” ХХК-иудтай тусгай зориулалтын “Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн төмөр зам” ХХК, “Чойбалсан-Хөөт-Бичигт төмөр зам” ХХК-ийг байгуулах Хувьцаа эзэмшигчдийн гэрээг тус тус байгуулав.

Зураг 12. Баруун, Зүүн босоо чиглэлийн төмөр замын төслүүдийн хөрөнгө оруулагч талуудын хамт (2023.06.15)



“Хөгжлийн сэргэлт” Зам, тээврийн салбарын залуучуудын зөвлөгөөн 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулагдаж “Монголын төмөр зам” ТӨХК-ийн төлөөлөл оролцов.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллах хүрээнд:

“Төмөр замын бүтээн байгуулалт, цаг үеийн сэдэв”-т хэвлэлийн хурал зохион байгуулж, өдөр тутмын сонин-3, телевиз-6, сайт-12 оролцож бүтээн байгуулалтын мэдээ мэдээллийг сурвалжлан түгээсэн.

- “Economy Mongolia” сэтгүүлтэй хамтран ажиллах хүрээнд холбогдох мэдээ мэдээлэл бэлтгэн тус сэтгүүлд нийтлүүлсэн.
- Тавантолгой Зүүнбаян чиглэлийн төмөр замаар шатахуун тээвэрлэлтийн үйл ажиллагаа зохион байгуулахаар хамтран ажиллах санамж бичиг үзэглэж буй үйл явцын талаар мэдээллийг Зам, тээврийн хөгжлийн яам болон мэдээллийн 6 сайтаар олон нийтэд түгээж ажиллав.
- Компанийн үйл ажиллагаатай холбоотой постер, нийтлэлийг “Ган зам” сонин, www.economy.mn, www.zarig.mn, www.itoim.mn, www.ganzam.mn зэрэг мэдээллийн сайтуудад тус тус нийтлүүлэн ажилласан.
- Тендерийн урилга, Үнийн санал авах урилга, Хараат бус гишүүн сонгон шалгаруулах зар, Тавантолгой Зүүнбаян чиглэлийн төмөр замын эрчим хүчний барилга, байгууламжийг улсын комисс хүлээн авсан талаар мэдээ мэдээллийг Зам, тээврийн хөгжлийн яамны пэйж хуудас болон сайтад, “Ган зам” сонин, www.tug.mn, www.arслан.mn, www.dobu.mn, “Өнөөдөр” сонинд тус тус нийтлүүлж ажилласан.

ТАНИЛЦСАН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН АХЛАХ
МЕНЕЖЕР

Б.ЦОГТГЭРЭЛ

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, АЖ АХУЙН АЛБАНЫ
МЕНЕЖЕР

Г.ГАНТҮШИГ

ТАЙЛАН МЭДЭЭ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Х.ЭРДЭНЭБАЯР

БОЛОВСРУУЛСАН:

ТАЙЛАН МЭДЭЭ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

Б.ЧАНЦАЛДУЛАМ

АГУУЛГА

1. ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗАР	1-4
1.1. Шуурхай хуралдаан	
1.2. Архив, албан хэрэг хөтлөлт	
1.3. Хүний нөөцийн чиглэлээр	
1.4. Худалдан авах ажиллагаа	
1.5. Хууль, эрх зүйн чиглэлээр	
2. ДОТООД АУДИТ	4-6
3. САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ГАЗАР	7
3.1. Нягтлан бодох бүртгэлийн алба	
3.2. Эдийн засгийн алба	
4. ИНЖЕНЕР ТЕХНОЛОГИЙН ГАЗАР	8-9
4.1. Зүтгүүрийн аж ахуйн алба	
4.2. Вагоны аж ахуйн алба	
4.3. Статистик мэдээлэл, технологийн алба	
4.4. Зураг төслийн алба	
5. СУУРЬ БҮТЦИЙН ГАЗАР	10-13
5.1. Барилга, эрчим хүчний алба	
5.2. Замын аж ахуйн алба	
5.3. Дохиолол холбооны алба	
6. ТЭЭВЭР ЛОГИСТИКИЙН ГАЗАР.....	13-16
6.1. Хөдөлгөөн зохион байгуулалтын хүрээнд	
6.2. Ачаа тээврийн алба	
7. ТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР.....	17-19
8. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨЛТ, ТЭСЛИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР.....	20-23
8.1. Стратеги төлөвлөлтийн хэлтэс	
8.2. Баруун болон зүүн босоо чиглэлийн төмөр замын төсөл	
8.3. Боомтын төмөр замын төсөл	
9. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ, БАЙГАЛЬ ОРЧНЫ АЛБА.....	23-26
10. ГАДААД ХАРИЛЦАА, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ АЛБА	26-29